

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,  
СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

---

Улаанбаатар хот  
2021 он

<b>АГУУЛГА</b>		<b>Хуудасны тоо</b>
<b>НЭГ.</b>	<b>ОРШИЛ</b>	
1.1.	Үнэлгээ хийх болсон шаардлага	3-5
1.2.	Үнэлгээ хийх хүрээг сонгосон байдал	5-7
1.3.	Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон түүний томьёолол	7-10
1.4.	Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгосон талаар	10
1.5.	Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар	10
<b>ХОЁР.</b>	<b>ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН</b>	
2.1.	“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	11-16
2.2.	“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	16-26
2.3.	“Зардал, үр өгөөжийн харьцаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	26-41
<b>ГУРАВ.</b>	<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	
3.1.	Үнэлэлт, дүгнэлт	42-46
3.2.	Санал, зөвлөмж	46-48
	<b>ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ ТОВЧИЛСОН ҮГ</b>	49
	<b>ХҮСНЭГТ, ХАВСРАЛТ МАТЕРИАЛ</b>	
Зураг 1.	Мэргэжлийн байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр: /2009-2019 он/	
Зураг 2.	МБСБ төгсөгчдийн эдийн засгийн идэвх /2018 он/	
Зураг 3.	МБСБ-ын элсэгчдийн тоо /2007-2018 он/	
Зураг 4.	Мөшгих судалгаанд хамрагдагчдын ур чадварын зөрүү	
Хүснэгт 1.	Сургалтын ангилал	
Хүснэгт 2.	Зардал шаардлагатай зохицуулалт	
Хүснэгт 3.	Гүйцэтгэх захиргааны үүрэг болон стандарт үйл ажиллагааны зардлын тооцоо	
Хүснэгт 4.	Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын нийт төгсөгчдийн тоо /2011-2018/	
Хүснэгт 5.	Нэг удаагийн тэтгэмжийн тооцоо	
Хүснэгт 6.	Хүний нөөцийн хэрэгцээний задлын тооцоо	
Хүснэгт 7.	Хүний нөөцийн төрөөс шаардагдах шууд зардлын тооцоо	
Хүснэгт 8.	Хуульд 5 жил тутам олгох нэг удаагийн тэтгэмжийн төрлийн зардлын тооцоо	
Хавсралт-1	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлага /2016-2020 оны төсөв, гүйцэтгэл/	
Хавсралт-2	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлага /2021 он/	

## НЭГ. ОРШИЛ

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно." гэж заасан байх тул Улсын Их Хурлын Тамгын газраас Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн (цаашид "МБСтХ" гэх) тухай хуулийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу гүйцэтгэлээ.

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь МБСтХ-ийн зорилгодоо хүрсэн түвшинг тогтоох, уг хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, зохистой үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дараах алхмуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож томъёолох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Богино хугацаанд төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах аргыг сонгож, цуглуулсан.

### 1.1. Үнэлгээ хийх болсон шаардлага

Улсын Их Хурлаас анх 2002 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг баталсан бөгөөд 2009 онд шинэчилсэн найруулгыг батлан өнөөг хүртэл хугацаанд хуулийг мөрдөн, хэрэгжүүлж байна. Уг хуульд батлагдсанаас нь хойш тухайн цаг үеийн нөхцөл байдал болон бусад хууль тогтоомжид орсон өөрчлөлттэй уялдуулан нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах нийт 5 бүлэг, 28 зүйлтэйгээр батлагдсан.

Тус хууль нь тухайн төрлийн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хууль батлагдсанаар нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээ хийх шалтгааныг зөв тодорхойлж гаргах шаардлага тавигдана.

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох ХНХЯ-наас хийсэн "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан"-д "Монгол Улсын үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологийн өнөөгийн хөгжлийн өсөлт, өөрчлөлт, нийгмийн эрэлт, олон улсын нийтлэг чиг хандлагатай уялдан үүссэн зарим харилцааг өнөөдөр мөрдөж буй МБСтХ бүрэн зохицуулж чадахгүй байна." гэж дүгнэсэн байна.<sup>1</sup>

<sup>1</sup> "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан" ХНХЯ, 2020, х-3

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

Түүнчлэн Улсын Их Хурлаас баталсан дараах бодлогын баримт бичгүүдэд мэргэжлийн боловсрол, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтуудыг дэвшүүлсэн байна.

<b>Бодлогын баримт бичгийн нэр</b>	<b>Зорилт</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>
Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан  “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО”	2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.	Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна.  Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна.
	2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.	Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлнэ.
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл	2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж төлөвшүүлнэ.	Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулсан байна.  Цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн тогтолцоог бэхжүүлсэн байна.
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж төлөвшүүлнэ.	Сургалтын цахим платформыг хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим контент, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.  Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ. Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.

Урт хугацаанд хэрэгжих дээрх бодлогын зорилтыг хангахад өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй МБСтХ мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх харилцааг бүрэн зохицуулах чадамжгүй байгаа юм. Энэ талаар тус хуулиар зохицуулж буй харилцаанд оролцогч талууд болох ажил олгогчид болон МБСБ-д суралцаж төгссөн иргэд өөрсдийн байр суурийг хэрхэн илэрхийлснийг үнэлгээний явцад тодруулсан болно.

Үнэлгээ хийх шалтгаан болон хүрээг тогтоохын тулд эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, эрдэмтэд, судлаачид болон хуулийн хэрэгжилтэд өртөж буй этгээдийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага, мөн Төрийн бус байгууллагын төлөөллөөс гаргасан

санал, ХНХЯ-аас боловсруулсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судалсан тайлан зэрэг дам эх сурвалжаас мэдээлэл цуглуулан судлахын зэрэгцээ статистикийн мэдээ, бусад анхдагч эх сурвалжийг /иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт г.м/ судлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн мэргэжлийн боловсрол сургалтын асуудлаарх бодлогын яам болон хэрэгжилтийг зохион байгуулж байгаа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн албан хаагчидтай биечлэн уулзаж, ярилцлага зохион байгуулж хуулийн хэрэгжилтийн талаар мэдээллийг тус тус авсан болно.

## **1.2. Үнэлгээ хийх хүрээг сонгосон байдал**

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар иргэдийн хөдөлмөр эрхлэх чадвар дээшилж, үүний үр дүнд хүн амын ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх ерөнхий зорилго, ажиллах хүчнийг бэлтгэх, бодлого, үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээтэй холбох механизмыг бүрдүүлж, сургалтын байгууллагын үйл ажиллагааг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгоно гэсэн дэд зорилгыг тус тус дэвшүүлсэн<sup>2</sup> бөгөөд зорилгодоо дараах арга замаар хүрнэ гэж хууль санаачлагч үзжээ. Үүнд:

1/хүний нөөц, ажиллах хүчний бодлоготой мэргэжлийн сургалт, техникийн боловсролын бодлогыг уялдуулахад ажил олгогч, хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, оролцоог хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2/нийгмийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого боловсруулах, хөгжлийн стратегийг тодорхойлох, төсөв хөрөнгийг хуваарилах, норм стандарт тогтоох, мөрдүүлэх, чанарын хяналт, баталгаажуулалтын чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;

3/мэргэжлийн сургуульд болон суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ ажил олгогчоос мэргэжлийн боловсрол, сургалтад санхүү, хөрөнгийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг урамшуулах, сургуулийн санхүүгийн эрх мэдэл, орлогоо нэмэгдүүлэх боломжийг дэмжсэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;

4/Засгийн газрын өөр өөр байгууллагад хуваарилагдсан чиг үүргийг нэгтгэх замаар мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зарцуулах хөрөнгө, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийг нэгдсэн зохицуулалттай, үр ашигтай удирдах шинэ зохион байгуулалтыг бий болгох;

5/мэргэжлийн сургалт, техникийн боловсролын онцлогтой уялдан цөөн тоогоор шаардагддаг мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг зохиох, хэвлэх, түгээхийг урамшуулсан зохицуулалтыг бий болгох;

6/мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх, багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллах, үйлдвэрлэлийн туршлагатай мэргэжилтнийг сургалтын ажилд оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, өгөөжийг сайжруулах;

7/хөдөлмөрийн зах зээлийн тоон болон чанарын судалгааг мэргэжлийн түвшинд хөтлөн явуулах зорилго бүхий мэдээллийн нэгдсэн сан байгуулах замаар аливаа шийдвэр, төлөвлөлтийг сайжруулах;

8/бүх төрлийн мэргэжлийн сургалтад нэгдсэн стандарт мөрдүүлэх.

<sup>2</sup> “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-аас, УИХТГ-ын архив

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

Тус хуульд үнэлгээ хийх болсон шалтгаан, түүнчлэн хуулийн зорилго, зорилгод хүрэх арга замыг харгалзан үзэж агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц дараах хэд хэдэн зүйл, хэсэг, заалтыг сонгож үнэлгээний хүрээг тогтоосон.

д/д	ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭ БУЮУ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ
1.	<p><b>6 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл</b>                      6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ.                      6.3.Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>
2	<p><b>8 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх</b>  <i>/Энэ зүйлийн гарчигт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийг хуулиар нэмэлт оруулсан/</i>                      8.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  <i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i>                      8.4.3.мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;                      8.4.5.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;</p>
3	<p><b>12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага</b>                      12.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.</p>
4	<p><b>14 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх</b>                      14.1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна.                      14.2.Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно.</p>
5	<p><b>15 дугаар зүйл.Суралцагч элсүүлэх</b>                      15.4.Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.</p>
6	<p><b>16 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ</b>                      16.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.                      16.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.</p>
7	<p><b>17 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг</b>                      17.1.2.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагаладангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;</p>
8	<p><b>18 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш</b>                      18.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.                      18.2.Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p>
9	<p><b>20 дугаар зүйл.Нийгмийн түншлэл</b>                      20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд дараахь түвшинд ажиллана:</p>
10	<p><b>26 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</b></p>

26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.
---

### 1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт ба түүний томьёолол

Үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдуулан өмнөх хэсэгт сонгож авсан зохицуулалтуудыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ. Үүнд:

- зорилгод хүрсэн түвшин;
- практикт нийцэж байгаа байдал;
- зардал-үр өгөөжийн харьцаа;

**Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томьёолсон. Үүнд:**

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн зорилго	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	<p><b>6 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл</b></p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ.</p> <p>6.3.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал</p> <p>Практикт нийцэж байгаа байдал</p>	<p>Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших</p>	<p>Үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаа эсэх?</p> <p>Зөвлөл бүрэн эрхээ хангалттай хэмжээнд хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх?</p> <p>Зөвлөл нь хуулийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх?</p> <p>Эрх, үүргийг тодорхойлсон хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байна уу?</p>
2	<p><b>8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын эрхэлсэн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх</b></p> <p>8.4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;</p> <p>8.4.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;</p>	<p>Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал</p> <p>Практикт нийцэж байгаа байдал</p>	<p>Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших</p> <p>Тохиолдол судлал</p>	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой тодорхойлж чадаж байна уу?</p> <p>Эрэлт хэрэгцээний үндсэн дээр суралцагч элсүүлж, улмаар ажлын байраар хангаж байгаа эсэх?</p> <p>Ажил олгогчдоос ирсэн захиалгын дагуу элсэгч авч байна уу?</p> <p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэж чадаж байна уу?</p>
3	<p><b>12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага</b></p>	<p>Практикт нийцэж байгаа байдал</p>	<p>Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс</p>	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн тодорхойлж байна вэ?</p>

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

	12.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.		хойших  Тохиолдол судлал	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгож чадаж байгаа эсэх?
4	<b>14 дүгээр зүйл.</b> <b>Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх</b> 14.1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна. 14.2.Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно.	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших  Тохиолдол судлал	Сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олголт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх?  Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг баталсан эсэх?
5	<b>15 дугаар зүйл.</b> <b>Суралцагч элсүүлэх</b> 15.4.Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших  Тохиолдол судлал	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн эрэлтийн судалгааг ямар давтамжтай хийдэг вэ?  Эрэлтийн судалгаанд үндэслэн суралцагч элсүүлдэг эсэх?  Хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон эмэгтэй суралцагчдын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлсэн эсэх?  Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээтэй уялдуулж эрэлтийг тодорхойлж чадаж байна уу?  Суралцагч хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?
6	16.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр	Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын



*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ. 16.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.		үйлчилж эхэлснээс хойших Тохиолдол судлал	үнэлгээний одоогийн тогтолцоо хангалттай түшинд хэрэгжиж байгаа эсэх?  Сургалтын чанарын үнэлгээг бодитой тогтоож чадаж байна уу?
7	17.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах эрхтэй. 17.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших  Тохиолдол судлал	Суралцагч хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?
8	18.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна. 18.2.Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших  Тохиолдол судлал	Мэргэжлийн сургалтын байгууллагын багшийн чадвар, чадамжийг үнэлэх тогтолцоо бий эсэх?  Багшийг чадавхжуулах, хөгжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг эсэх, сургалтын үр дүнг хэрхэн хэмждэг вэ?
9	<b>20 дугаар зүйл.</b> <b>Нийгмийн түншлэл</b> 20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр	Зорилгод хүрсэн түвшин ба хэрэгжсэн байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	Нийгмийн түншлэлийн хүрээнд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгож чадаж байна уу?  Нийгмийн түншлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн хувьд дэмжлэг, зохицуулалт шаардлагатай байна уу?  Нийгмийн түншлэл хамгийн сайн хэрэгжиж байгаа үйл ажиллагааны ямар чиглэл

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	ажиллаж болох бөгөөд дараахь түвшинд ажиллана:			/сургалт, дадлага, ажлын байр гэх мэт/ байна вэ? Төрийн болон төрийн бус байгууллагын оролцооны түвшин хэр байна вэ?
10	<b>26 дугаар зүйл.</b> <b>Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</b> 26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.	Зорилгод хүрсэн түвшин ба хэрэгжсэн байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших  Тохиолдол судлал	Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн хэрэгжилт хяналт тавих механизм бүрдсэн эсэх?  Мэргэжлийн хяналтын байгууллага хангалттай хэмжээнд хяналт тавьж чадаж байна уу?  Хууль тогтоомжоор тус байгууллагад олгосон эрх хангалттай эсэх?  Тулгарч байгаа асуудал, хүндрэл бэрхшээл?

#### **1.4.Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгосон талаар**

Үнэлгээ хийх явцад харьцуулах хэлбэрийг сонгохдоо МБСтХ-ийн хэрэгжилтийн өнөөгийн явц байдал болон гарсан үр дүнг харьцуулах, мөн практикт хэрхэн хэрэгжиж буйд дүн шинжилгээ хийх зорилгоор хэмжигдэхүйц мэдээллийг цуглуулж, тухайн салбарт гарсан өөрчлөлтийг үнэлэхэд анхаарсан. Тухайлбал, уг хуулиар дэвшүүлсэн зорилтдоо ямар түвшинд хүрсэн эсэхийг тогтоохын тулд байх ёстой ба одоо байгаа үр дүнг үнэлэхээр үнэлгээний хавсралт болон сонгож үнэлсэн зохицуулалт бүрийн доор эш татсан тайлан, статистикийн мэдээлэл, судалгаа зэргийг уншиж судлан, дүгнэлт, боловсруулалт хийсэн. Түүнээс гадна уг хуулийг хэрэгжүүлж буй болон хуулийн үйлчлэлд хамаарч байгаа этгээдийг хамруулсан тодорхой тохиолдлыг судалсан.

#### **1.5.Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар**

Үнэлгээнд ашиглах мэдээлэл цуглуулахад цаг үеийн нөхцөл байдал нөлөөлж сургалтын орчинд суралцагч болон багш нартай уулзах, анги танхим, техник хангамжийн талаар биечилсэн сурвалжлага, ярилцлага авах боломж байгаагүйг дурдах нь зүйтэй.

Гэсэн хэдий ч боломжит нөөц бололцоонд тулгуурлан үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа хууль хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллүүдтэй биечлэн уулзаж мэдээлэл цуглуулахыг сацуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО, ХНХЯ, БШУЯ, МБСҮТ зэрэг байгууллагын тайлан мэдээ, статистик, <http://yamat.mlsp.gov.mn/><sup>3</sup>, [www.barilqa.mn](http://www.barilqa.mn), <http://hudulmur-halamj.gov.mn/occ>, [www.1212.mn](http://www.1212.mn)-ыг ашигласан.

<sup>3</sup> Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /Европын холбооны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн/

## ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### 2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа:

#### 6 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл

Үнэлэх хэсэг	6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ. 6.3.Зөвлөлийн бүрэн эрх.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- Үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаа эсэх?</li><li>- Үндэсний зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл байгаа эсэх?</li><li>- Үндэсний зөвлөл нь хуулийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх?</li><li>- Эрх, үүргийг тодорхойлсон хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байна уу?</li></ul>

Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагаа, бүрэн эрхийг тус хуулийн 6 дугаар зүйлээр зохицуулсан.

Мөн энэхүү хуулиар “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ” гэж зааж, түүний бүрэн эрхийг тодорхойлон, мэргэжлийн боловсрол, сургалтын санхүүжилтийн тогтолцоог үүнтэй уялдуулж өгсөн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл хуульд заасан хэмжээнд ажиллаж чадаагүй гэж салбарын мэргэжилтнүүд болон салбарын хүрээнд хийгдсэн судалгаануудад дүгнэсэн бөгөөд үүний гол шалтгааны нэг нь гүйцэтгэх чиг үүрэг нь нэмэгдсээр ирсэн Үндэсний зөвлөлийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн орчин хязгаарлагдмал, хангалтгүй байсантай холбоотой гэж үзжээ.<sup>4</sup>

Тус Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батлахаар заасан.

Үндэсний зөвлөл Засгийн газар, түүний байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд Засгийн газрыг төлөөлөх 9, хувийн хэвшлийг төлөөлөх 9 буюу нийт 18 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллах ёстой. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2009, 2011, 2012, 2016, 2017 онуудад тус тус өөрчлөн болон шинэчлэн баталж, ажиллуулжээ.

Засгийн газрын 2016 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн дүрэм”-д зааснаар “Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл нь бүрэн эрхийнхээ хүрээнд жилд 4 удаа, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гишүүдийн гуравны нэгийн саналаар ээлжит бусаар хуралдаж, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын үйл ажиллагааг дэмжин ажиллах үүрэгтэй гэж заасан. Гэвч 2009 оноос хойших 11 жилийн хугацаанд ердөө 16 удаа хуралдсан нь хангалтгүй үзүүлэлт байна.

Үндэсний зөвлөлийн төрийг төлөөлсөн бүрэлдэхүүнд яамдын төрийн нарийн бичгийн дарга нар багтдаг бөгөөд ирц хүрч, бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах тохиолдол байдаггүй,

<sup>4</sup> ХНХЯ. 2017. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

ажлын шаардлагаар төлөөллөө хуралд оролцуулах нь нийтлэг байдаг байна. Түүнчлэн Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэр, зөвлөмжийнхээ хэрэгжилтэд хяналт тавих талаар хангалтгүй ажиллажээ.

Тус Үндэсний зөвлөлийн салбар зөвлөл нь салбарын чиг хандлагыг тодорхойлох, ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн стандарт, хөтөлбөр боловсруулахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг боловч өнөөдрийн байдлаар барилга, авто зам, хүнс, уул уурхайн 4 салбар зөвлөл, 14 чиглэлийн мэргэжлийн зөвлөлүүд тус тус байгуулагдан үйл ажиллагаагаа төлөвшүүлэх шатандаа байна.

Харин бусад салбарын салбар зөвлөл одоог хүртэл байгуулагдаагүй байгаа нь салбарын үйл ажиллагаанд саад учрах, урагшлахгүй байх сөрөг үр дагавартай байна. Мөн Үндэсний зөвлөл болон салбар зөвлөл, тэдгээрийн эрх үүргийг нарийвчлан тогтоогоогүй, зөвхөн ерөнхий байдлаар тодорхойлсон байгааг илүү нарийвчлан тодорхой болгох, хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, мөн тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэн хамтран ажиллах шаардлага зайлшгүй байгааг судалгааны тайлан болоод тэдгээрээс гарсан зөвлөмжүүдэд нийтлэг дурдсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хийгдсэн тандан судалгааны тайланд Үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, ажиллах боломж хязгаарлагдмал, салбар зөвлөлүүдийг ажиллуулах зохицуулалт тусгагдаагүйгээс мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо хангалтгүй сул, түншлэлийн үр нөлөө хангалтгүй гэж дүгнэсэн байна.

ЮНЕСКО-гоос 2019 онд хийсэн “Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ” бодлогын судалгааны тайланд дараах асуудлуудыг онцолж, дүгнэлт зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- *Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл (МБСҮЗ) болон салбар зөвлөлүүд хууль журамд заасан эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгааг дурдаад МБС-ыг удирдах тогтолцоо 2012 оноос хойш тогтвортой бус байна (БХ, 2019). Голчлон яамны нэг нэгж, хэлтэс хариуцан удирддаг нь шийдвэр гаргалт удаан, хүн хүч хүрэлцээгүйн улмаас бүрэн дүүрэн удирдлагаар хангаж чаддаггүй.*
- *МСҮТ-ийн удирдах ажилтныг томилох асуудал дээр улс төрийн нөлөө маш их байдаг. (БХ, 2019). Одоогийн байдлаар, шийдвэр гаргалтад төрийн болон хувийн хэвшлийн оролцоог тэнцвэржүүлэх, шийдвэрийг төрийн, хувийн салбарт аль алинд нь хэрэгжүүлэх, МБС-ын санхүү төсвийг шийдвэрлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, МБС-ын байгууллагын удирдлагад хяналт шинжилгээ хийх (санхүүжилт, төсөв хөрөнгө, хариуцлага) салбарын тогтвортой байдлыг хангах үүднээс удирдлагын тогтолцоонд МБСҮЗ ордог байна. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас МБС-ыг Дэмжих сангийн санхүүжилт хийгдэхгүй, МБСҮЗ-ийн үйл ажиллагаа тогтмол бус байна гэж дүгнээд Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын удирдлагыг бэхжүүлэх, мэргэшүүлэх шаардлагатай гэх зөвлөмжийг өгсөн байна.*

*Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний зарим бүрэн эрхийн хэрэгжилт:*

**8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх**

Үнэлэх хэсэг

8.4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;  
8.4.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

Томьёолсон шалгуур үзүүлэлт

- 15.4. Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой тодорхойлж чадаж байна уу?
  - Эрэлт хэрэгцээний үндсэн дээр суралцагч элсүүлж, улмаар ажлын байраар хангаж байгаа эсэх?
  - Ажил олгогчдоос ирсэн захиалгын дагуу элсэгч авч байна уу?
  - Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэж чадаж байна уу?

**Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага, зохион байгуулалтыг түүхчилж харуулбал:**

Хугацаа	Харьяалах байгууллага	Гарсан ололт, дэвшил
1961-1976	СНЗ-ийн Дээд, тусгай дунд, техник мэргэжлийн Улсын хороо	Салбар дундын зохицуулалт хэрэгжиж, яамдын үйл ажиллагааг уялдуулж, сургууль, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг үр нөлөөтэй болгож чадсан.
1982	АБЯ-ны бүтцэд Техник мэргэжлийн сургуулийг удирдах Ерөнхий газар	Ерөнхий газрыг 1990 онд татан буулгаж, ТМС-уудыг яам, аймгуудад тараж өгсөн. МБС-ын нэгдсэн бодлого алдагдаж, агуулга, арга зүйн дэмжлэг туслалцаа зогсонги байдалд орсон.
1990-1999	Гэгээрлийн яам	Яаманд МБС-ын асуудлыг мэргэжилтэн хариуцах болсон.
2000-2009	БСШУЯ-д Мэргэжлийн боловсролын арга зүйн төв	МБМБ-ыг дэмжих, баш нарыг чадваржуулахад ахиц өөрчлөлт гарсан.
2009	ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлагийн статустай Мэргэжлийн боловсрол, сургалтын газар	Энэ тогтолцоо нь олон улсын жишиг, эрэлтэд нийцсэн, оновчтой тогтолцоо болохоо богино хугацаанд харуулсан.
2012, 2016, 2018	ХНХЯ-д МБС-ийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, /2018 онд хэлтэс/	Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлыг ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилттой уялдуулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болсон.

*Эх сурвалж: Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. БСШУЯ, 2019 он.*

Хуулийн зорилт болон Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд нийтлэг тусгагдсан нэг асуудал бол хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн мэргэжилтэй ажилтанг сургах, улмаар ажлын байраар хангахаар тусгасан байна.

Бодит байдал дээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хэрхэн, яаж тодорхойлж, уг эрэлтийн дагуу мэргэжилтэй ажилтанг сургаж, бэлтгэж, улмаар ажлын байраар хангаж чадаж байна уу гэдэг асуудал гарч байна. Үнэхээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг үнэн зөв тодорхойлж, ямар ажил мэргэжил, ажлын байр, ур чадвартай ажилтан хэрэгтэй байна гэдгийг урьдчилан судалж тодорхойлоод, ажил олгогчоос ирүүлсэн захиалгын дагуу ажилтанг сургаж, нийлүүлж чадаж байна уу, чадаж байвал эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүсэхгүй буюу төгсөгчид бүгд ажилтай байх учиртай. Гэвч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2018 онд хийсэн “Мэргэжлийн боловсрол, сургалтын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-аар төгсөгчдийн 50 гаруй хувь л ажилтай болсон байна.

“Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана” гэсэн заалт байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг бодитоор тодорхойлж чадахгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа судалгааны институтээс хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилготой “Барометрийн судалгаа”-г хийж эхлээд 11 жил болж байна. Тус судалгаагаар ирэх оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, мөн өнгөрсөн нэг жилийн хугацаан дахь ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, байршлаар тодорхойлж, тодорхой суурь мэдээлэл, санал зөвлөмж боловсруулахад чиглэсэн хэдий ч тус судалгаа эрэлтийг бодитойгоор тодорхойлж чадахгүй байна.

Мөн ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрт шаардлагатай байгаа ажилтны эрэлт, хэрэгцээний талаар албан ёсоор мэдээлэл, захиалга өгдөггүй, зарим тохиолдолд судалгаа авах төдийгээр хязгаарлагдаж ирсэн. Улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг болон төгссөн суралцагчдын ажил эрхлэлтийг бодитой тодорхойлж чадахгүй гэж үзэж болох юм.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрын судалгаанаас харахад Хөдөлмөрийн зах зээлд 2020 онд зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс шалтгаалан 20.6 мянган ажиллах хүчний хомсдол бий болсон гэх бөгөөд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээний салбар, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбар хамгийн ихээр өртсөн байна. Мэргэжлийн боловсролын сургалтын тогтолцоогоор дамжуулан бэлтгэдэг жолооч, тогооч, зөөгч, засалчин, шаварчин, барилгачин, нарийн мужаан зэрэг ажил мэргэжилд ажиллах хүчний хомсдол байгааг судалгаагаар харуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн хувь, ажлын байранд тавигдах шаардлагыг зэргээр тодорхойлдог түвшинд хангаж ажиллаж байгаа эсэх буюу эзэмшсэн ур чадвар, хандлага төлөвшил юм. Нөгөө талаас ажил хайгч иргэн тогтвортой ажиллах хүсэлгүй, ачаалал даах чадваргүй, цалин хөлс бага, ажлын хангалттай туршлагагүй байх нь ажил олгогчид шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл хэвээр байна. Эдгээр шалтгаан нь сүүлийн 5 жилийн судалгаагаар удаа дараа нэрлэгдсээр байна.

Суралцагчдад техникийн ур чадвараас илүү хандлага, төлөвшил, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, харилцах, бие даан бизнес эрхлэх гэх мэт мэргэжилтэй ажилтанд зайлшгүй эзэмшсэн байх ур чадвар, хандлагыг хөгжүүлэх асуудал дутагдалтай байгааг салбарын шинжилгээний үр дүн харуулж байна. Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байранд тавигдах мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүнд тавигдах ерөнхий ур чадварууд төгсөгчдөд хангалттай бус байна.<sup>5</sup>

Төгсөгчид ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх талаар авсан ажил олгогчдоос авсан чанарын судалгаа улсын хэмжээнд байхгүй байна.<sup>6</sup> Нөгөөтэйгүүр ажил олгогчид ур чадвартай ажилтны эрэлтийг нөхөхийн тулд гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах /ялангуяа барилга, уул уурхайн салбарт ажлын байр байдаг ч ажилчдын ур чадвар нь тухайн байгууллагын тавьж буй шаардлагад нийцдэггүй/ байдлаар нөхөх явдал байсаар байгаа нь гадаадын ажиллах хүчний тооноос харагдаж байна.

Сүүлийн арваад жилийн хугацаанд МБС-ын салбарын хүрээнд гаднын тусламж, дэмжлэгээр олон тооны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж ирсэн бөгөөд салбар дундын асуудал учраас боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн талаас салбарын суурь судалгаанууд хангалттай түвшинд хийгдэж, асуудлуудыг тодорхойлж, холбогдох зөвлөмжүүдийг өгсөн байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) Монгол Улсын өрсөлдөх чадварын талаар судалгаа хийснээр ур чадварын хомсдол нь ажиллах хүчний нэг гол асуудал байсаар байгааг онцолсон байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажиллах

<sup>5</sup> ХНХСИ. (2018). Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

<sup>6</sup> Фокус бүлгийн ярилцлага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

хүчний тоон мэдээллээс гадна шаардлагатай байгаа ажиллах хүчний ур чадвартай холбоотой судалгааг тогтмол хийснээр МБС-ын чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх боломжтой гэж үзжээ.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэлийн хэрэгжилт:*

Үнэлэх хэсэг **20 дугаар зүйл. Нийгмийн түншлэл**

Томьёолсон  
шалгуур  
үзүүлэлт

- *Нийгмийн түншлэлийн хүрээнд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгож чадаж байна уу?*
- *Нийгмийн түншлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн хувьд дэмжлэг, зохицуулалт шаардлагатай байна уу?*
- *Нийгмийн түншлэл хамгийн сайн хэрэгжиж байгаа үйл ажиллагааны ямар чиглэл /сургалт, дадлага, ажлын байр гэх мэт/ байна вэ?*
- *Төрийн болон төрийн бус байгууллагын оролцооны түвшин хэр байна вэ?*

Монгол Улс МБС-ын тогтолцоог төрийн болон хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурлан олон улсын түвшинд хүргэхээр салбар дамнасан бодлого баримталж, МБС-ын төгсөгчдийн ур чадвар нь ихэнхдээ чадамжид суурилсан сургалт, багшийн ур чадвар, сургалтын орчин, дадлага хийсэн байдал зэргээс хамаарч байна. МБС-ын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтээр удирдуулсан, салбар дундын зохицуулалт онцлогтой салбар тул ажил олгогчийн оролцоо, бусад салбарын дэмжлэггүйгээр үндэсний ажиллах хүчнийг бэлтгэх боломжгүй тул төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилан хөгжүүлэх зорилтыг тавин ажиллаж ирсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2009 онд хийсэн шинэчилсэн найруулгаар Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангасан Үндэсний зөвлөл байгуулж, тус зөвлөл нь МБС-ын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ гэж хуульчилсан. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг (төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог 50:50 харьцаатай байхаар заасан) 2009 онд баталж хэрэгжүүлж эхэлсэн.

Мөн салбарын хэмжээнд салбарын зөвлөл, орон нутгийн түвшинд аймаг, орон нутгийн зөвлөл, сургалтын байгууллагын түвшинд сургалтын удирдах зөвлөл зэрэг олон талын төлөөлөл бүхий нийгмийн түншлэлд тулгуурласан зөвлөл ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлсэн гэж байгаа боловч салбар зөвлөлийн үйл ажиллагаа байнгын тогтвортой бус, чиг үүрэг тодорхойгүй давхардсан, санхүүжилт болон хүн хүч хангалтгүй зэрэг асуудлууд байна.

Өнөөгийн байдлаар уул уурхай, барилга, авто зам, хүнсний үйлдвэрлэлийн салбар зөвлөлүүд байгуулагдсан. Эдгээр зөвлөлийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоо бүрдээгүйн улмаас үйл ажиллагаа нь зогсонги, шинэ салбар зөвлөл нэмэгдэхгүй байна.

Сургалтын байгууллагын түвшинд нийгмийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлж, дадлагын сургалтын чанарыг сайжруулах зорилготой аж ахуйн нэгж байгууллага, суралцагч, сургууль гурван талт гэрээ байгуулах замаар ажиллаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс өгсөн мэдээллээр нийгмийн түншлэлийн хүрээнд:

- Төрийн байгууллага / Яам, орон нутаг/
- Мэргэжлийн холбоо /16 салбарын 102 холбоод/
- Мэргэжлийн зөвлөл /24 мэргэжлийн зөвлөл/
- Үндэсний хэмжээний төрийн бус байгууллага /МАОЭЗНХ, МХАҮТ, МҮЭХ/
- ААНБ / 16 салбарын 349 байгууллага/ хамтран ажиллаж байна.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх нь дан ганц төрийн үүрэг биш бөгөөд мэргэжлийн зөвлөлүүд нь МБС-ын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, ажил олгогч

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

сургалтын байгууллагын хамтын ажиллагааг дэмжиж салбар дундын үйл ажиллагааг уялдуулахад чиглэн ажиллаж байна.

Нийгмийн түншлэлийг элсэлт, сургалт, үнэлгээ, ажлын байртай холбох үйл ажиллагаанд ажил олгогч, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны идэвхтэй оролцоог хангах тал дээр үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

*Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих:*

Үнэлэх хэсэг	<b>26 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</b>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизм бүрдэж чадсан эсэх?</li><li>- Мэргэжлийн хяналтын байгууллага хангалттай хэмжээнд хяналт тавьж чадаж байна уу?</li><li>- Хууль тогтоомжоор тус байгууллагад олгосон эрх хангалттай эсэх?</li><li>- Тулгарч байгаа асуудал, хүндрэл бэрхшээл? Хяналтын хүрээнд ямар арга хэмжээ авч, ямар үр дүн болон өөрчлөлтүүд гарсан?</li></ul>

Хуулийн 26 дугаар зүйлийн 1-д Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавихаар заасан. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих болон хариуцлагын тал дээр хяналт тавих механизм бүрдээгүй, салбар хоорондын болон төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгааг фокус бүлгийн ярилцлагуудад онцолж байсан.

Хуулийн дээрх заалтын хүрээнд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаа хангалтгүй байсан болно.

**2.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:**

*Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага зохицуулалтын хэрэгжилт:*


	<b>12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага</b>
Үнэлэх хэсэг	12.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн тодорхойлж байна вэ?</li><li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгож чадаж байгаа эсэх?</li></ul>

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.” гэж заасан.

Монгол Улсад өнөөдөр төрийн ба хувийн хэвшлийн нийт 86 МБС-ын байгууллага үйл ажиллагаа явуулж, барилга, зам тээвэр, уул уурхай, санхүү, бизнес худалдаа, хот байгуулалт зэрэг 15 салбарын 192 мэргэжлээр жилд дунджаар 20 орчим мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, хөдөлмөрийн зах дээр нийлүүлж байна. Мэргэжлийн сургалтын эдгээр байгууллагуудад нийт 37039 суралцагч суралцаж, 2469 багш, 2155 ажилтан, ажилчид ажиллаж байна. (ХНХЯ, 2018-2019). 2020-2021 оны хичээлийн жилд 40169 хүн МСҮТ-д суралцаж байна.



Зураг 1. Мэргэжлийн байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр: /2009-2019 он/



Мэргэжлийн сургалтын байгууллага нь МСҮТ, политехник коллеж, үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, тусгай хэрэгцээт сургалтын байгууллага зэрэг хэв шинжтэй байна.

Мэргэжлийн сургалтын байгууллага хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүргээ хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгааг дараах судалгааны дүн, тоо баримт нотлон харуулж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын 60 орчим хувь нь 10-40 хүртэлх ижил мэргэжлээр давхардуулан сургаж, илүүдэлтэй ажилтныг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байна.<sup>7</sup> гэсэн судалгааг салбарын яамнаас хийсэн байна. Мөн 2017 оны байдлаар ажилгүйчүүдийн 66 хувь нь техник мэргэжлийн, тусгай дунд болон дээд боловсролтой иргэд байгаа бол үлдсэн 34 хувь нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой иргэд байна.

Түүнчлэн Монгол Улсад жилд дунджаар 27,5 мянган гадаад иргэн ажиллаж, дийлэнх хувь нь барилга, уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь дотоодын мэргэжилтэй ажилтны хөдөлмөрийн зах зээлийн боломжийг хумих нэг нөхцөл болж байна.

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэн гаргахад чиглэсэн судалгааг холбогдох байгууллагуудаас тухай бүр гүйцэтгэдэг. Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс МБСБ-ын төгсөгчдийн эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлтийн талаар, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс “Политехник коллежийн зорилтот мэргэжлийн төгсөгчдийн мөшгих судалгаа ба ур чадварын зөрүүг тодорхойлох нь” зэрэг судалгаануудыг хийсэн нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллээр холбогдох байгууллагыг хангахад чиглэсэн байна.

Зорилтот мэргэжлийн 398 төгсөгчийг хамруулсан төгсөгчдийн мөшгих судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 201 төгсөгч буюу 52 хувь нь ажил эрхэлж байна. Судалгаанд оролцогчдын 64 хувь нь энэ ажлын байран дээрээ тогтвор суурьшилтай ажиллах бодолгүй ба шалтгаан нь мэргэжил, мэдлэг, ур чадварт тохирохгүй байгаа гэж хариулсан байна.

Мөн ажил эрхэлж буй төгсөгчдөд ажил олгогчоос шаардаж буй ажил эрхлэхэд шаардагдах ур чадварын хэрэгцээг судлахад гадаад хэл, яриа болон бичгийн чадвар, компьютер техник хэрэгсэл дээр ажиллах чадварын шаардлага ихэнх хувийг буюу 42 хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан нийт ажилтай төгсөгчдийн ур чадварын гүйцэтгэлд өгсөн

<sup>7</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан өөрийн үнэлгээгээр 69 хувь нь тухайн мэргэжлийн чадамжуудыг суралцах зайлшгүй шаардлагатай хэмээн үзсэн<sup>8</sup> байна.

Зураг 2. МБСБ төгсөгчдийн эдийн засгийн идэвх /2018 он/



Дээрх судалгаанаас харахад суралцагчдыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэх чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, ажлын байрны шаардлагад нийцүүлсэн чанартай боловсон хүчин дутагдалтай байгааг харж болно.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх:

**14 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх**

Үнэлэх хэсэг

14.1. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна

14.2. Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно.

Томъёолсон шалгуур үзүүлэлт

- Сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олголт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх?
- Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг баталсан эсэх?

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна.”, 14.2-т “Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно.” гэж тус тус заасан.

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх байгууллага нь төрийн болон хувийн өмчийн аль ч хэлбэртэй байсан зайлшгүй тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагыг хуулиар тогтоосон.

Харин богино хугацааны сургалтын байгууллагын тухайд тусгай зөвшөөрөл шаарддаггүй, зөвхөн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгодог. Саяхныг хүртэл богино хугацааны сургалт нь аль ч хуулийн этгээд эрхлэн явуулах боломжтой бизнес хэлбэртэй байсан учраас 2000 гаруй байгууллага бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байжээ. 2018 оноос ХНХЯ-аас түр сургалтын байгууллагуудыг бүртгэх журмыг шинэчилж, чанарын баталгааг

<sup>8</sup> “7 Политехник коллежийн зорилтот мэргэжлийн төгсөгчдийн мөшгих судалгаа ба ур чадварын зөрүүг тодорхойлох нь” Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв. 2020.

хангах үүднээс тодорхой нөхцөлүүдийг тусгаж шаардлагыг өндөржүүлсэн<sup>9</sup> байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтаар одоогийн байдлаар 1039 түр сургалтын байгууллага бүртгэлтэй байгаагаас 392 нь чадамж эзэмшүүлэх, 228 нь хэлний төв, 419 нь жолооны курс ажиллаж байгаа талаар мэдээллийг өгсөн.

Албан ёсны МБСБ ихэвчлэн залуучуудыг чиглүүлдэг бол албан бус мэргэжлийн сургалт (богино хугацааны сургалтын байгууллагууд) орон нутгийн хөдөлмөр, халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй хүмүүст, ур чадваргүй насанд хүрэгчид, эмзэг бүлгийнхэн, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөдөө орон нутгаас шилжиж ирсэн иргэдэд ажилд ороход нь туслах зорилгоор үйлчилгээ үзүүлж хөдөлмөр эрхлэх ур чадвар олгож байна. МБСБ төгсөгчдийн ажилгүйдэл хотод 32.8 хувь, хөдөө орон нутагт 67.2 хувьтай байна.<sup>10</sup>

Мэргэжлийн сургалтын бүх байгууллага сургалтын байр, тоног төхөөрөмж, багшлах боловсон хүчний чадавх, мэргэжлийн дадлага хийлгэх чадамжтай зэргийг нотолж баталгаажуулах үүрэгтэй. Богино хугацааны сургалт үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын бүртгэлд тавигдах шаардлагыг шинэчилж чадамжид суурилсан арга хандлагыг баримтлахыг шаарддаг болсон бөгөөд ингэснээр албан болон албан бус сургалтын байгууллагын ялгаа багасана гэж салбарын яам үзэж энэ чиглэлийн бодлогыг баримтлан ажиллаж байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулах ба тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан. Хуулийн энэ зохицуулалтыг хэрэгжүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Шаардлага, загвар батлах тухай” 2018 оны А/104 дүгээр тушаалаар дээрх шаардлага, загварыг батлан хэрэгжүүлж байна.

#### Суралцагч элсүүлэх:

#### 15 дугаар зүйл. Суралцагч элсүүлэх

Үнэлэх хэсэг	15.4. Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн эрэлтийн судалгааг ямар давтамжтай хийдэг вэ?</li><li>- Эрэлтийн судалгаанд үндэслэн суралцагч элсүүлдэг эсэх?</li><li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон эмэгтэй суралцагчдын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлсэн эсэх?</li><li>- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээтэй уялдуулж эрэлтийг тодохойлж чадаж байна уу?</li><li>- Суралцагч хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?</li></ul>

2020-2021 оны хичээлийн жилд 40169 хүн МСҮТ-д суралцаж байна. Энэ тоонд ПК, МСҮТ-үүд болон их, дээд сургуулиудын харьяа МБСБ-уудад суралцаж байгаа суралцагчид хамрагдаж байгаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангиа төгсөж МБСБ-д шинээр элсэгчдийн тоо 2015-2016 оны хичээлийн жилд 10388 байсан бол 2016-2017 оны хичээлийн жилд 5455 болж хоёр дахин буурсан. 2016-2017 оны хичээлийн жилээс тогтвортой өссөөр 2020-2021 хичээлийн жилд 9031-д хүрчээ. Харин энэ хугацаанд 12 дугаар ангиа төгсөөд МБСБ-д шинээр

<sup>9</sup> Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ. 2019

<sup>10</sup> Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн тайлан. БСШУЯ, 2019.

элсэгчдийн тоо аажмаар буурсан байна. Тухайлбал, 2011-2012 оны хичээлийн жилд ЕБС-ийн 4094 төгсөгч МБСБ-д элсэж байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 2097 төгсөгч элсэн оржээ.

Суурь боловсрол эзэмшсэн суралцагчдын 10 хувь нь дараагийн шатанд шилжиж байгаа бол 20 хувь нь мэргэжлийн боловсролын байгууллагуудад шилжин суралцаж байна. Тэгвэл ахлах сургууль төгсөж, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдийн 80 хувь их дээд сургууль, коллежид орж байгаа бол дөнгөж 10 хувь нь МБС-ын байгууллагуудад элсэн суралцаж байна.

Суралцагчийн бүтцийн хувьд хэд хэдэн анхаарал татсан асуудлууд байна. Үүнд:

Боловсролын бусад дэд салбаруудтай харьцуулахад МБС-д хамрагдах эмэгтэй суралцагчдын тоо хамгийн бага (39%) үзүүлэлттэй байгаа нь эмэгтэй суралцагчид МБС-аас илүүтэйгээр дээд боловсролд элсэн суралцдаг хандлагатай холбоотой.<sup>11</sup>

Мөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч МБСБ-ын нийт суралцагчдын 5 орчим хувиас илүүгүй байдаг. Улсын хэмжээнд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв гэсэн ганцхан байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн сургалт явуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо өсөхгүй байгаа нь тусгай хэрэгцээнд нийцсэн тусгай хөтөлбөр байхгүй, суралцах таатай орчин бүрдээгүй байгаатай холбоотой байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас, түүнчлэн ажлын байрны хүрэлцээ, хангамж, суралцах орчин нөхцөл зэргээс шалтгаалж эмэгтэй суралцагчдын болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эзлэх хувь өсөхгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана” гэж заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс МБСБ-ын төгсөгчдийн эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлтийн талаар, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс зорилтот мэргэжлийн төгсөгчдийн мөшгих судалгаа зэргийг хийхээс гадна сургууль бүр хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хийдэг.


Гэвч хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээлэл ерөнхий байгаагаас элсэлтийг оновчтой төлөвлөх, зохион байгуулахад хүндрэлтэй, мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудал хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд төдийлэн нийцэхгүй, оновчтой бус байгаа нь 40 гаруй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд давхардуулан сургаж байгаа, төгсөгчид ажлын байраар бүрэн хангагдаж чадахгүй байгаа зэргээс харагдаж байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д “Ажил, мэргэжлийн тодорхой чадамжийг эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, давтан суралцах хүсэлтэй иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад нас, боловсролын түвшин харгалзахгүйгээр хөдөлмөр эрхлэх мэргэжлийн болон аж ахуй эрхлэх сургалтад хамрагдана” гэж заасан.

Хэдийгээр Засгийн газраас МБС-ын элсэлтийг урт хугацааны бодлогоор дэмжин дунд сургууль төгсөгчдөөс багадаа гэхэд 20 хувь, ахлах сургуулийн төгсөгчдийн 10 хувийг элсүүлэх чиглэл барьж МБС-ын сургалтыг үнэ төлбөргүй санал болгож, МБС-ын байгууллагын өмчийн хэлбэрээс үл хамааран оюутан бүрд тэтгэлэг олгох болсон ч элсэлт өнөөг хүртэл хангалттай өсөхгүй байна.

<sup>11</sup> Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ. ЮНЕСКО, 2019.

Зураг 3. МБСБ-ын элсэгчдийн тоо /2007-2018 он/



Иргэнд мэргэжлийн боловсрол олгох асуудлыг төрөөс дэмжиж бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч ирсний нэг хэлбэр нь суралцагчид олгох тэтгэмж юм. МБСБ-уудад суралцагч оюутны тоо 2008 онд оюутанд сар бүрийн тэтгэмж олгож эхэлснээс хойш 40 мянгад хүрч, тэтгэмжийг зогсоосон 2016-2018 онуудад суралцагчдын тоо нилээд буурсан. Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор суралцагчдад олгох сар бүрийн тэтгэмжийг сэргээж, хэмжээг нь нэмэгдүүлэх шийдвэр гарсан.

Суралцагчдад олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тоог нэмэгдүүлэх гол хөшүүрэг мөн хэдий ч зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх чиглэлд түлхүү анхаарч мэдээллийн сан бүрдүүлж, ороцогчдыг байнга мэдээллээр хангах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг энэ чиглэлээр нарийвчлан боловсруулах шаардлага байна.

**Төгсөлт:** Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 2016-2017 оны хичээлийн жилд нийт 17489 төгсөгчдөөс 53 хувь нь буюу 9410 ажлын байртай болсон бөгөөд үүнээс 5727 нь буюу 61 хувь мэргэжлээрээ ажилд орсон байна.<sup>12</sup>

МБС-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018*)-ны дүнгээс үзэхэд МБС-ын төгсөгчдийн гуравны нэгээс бага хувь нь суралцсан чиглэлдээ холбогдох ажил эрхэлж байна.

Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан (*БСШУЯ, 2019 он*)-д дурдснаар 2017, 2018 онд эрүүл мэнд, эрчим хүч, тээвэр, уул уурхай, аж үйлдвэр, соёл урлаг зэрэг салбарын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өссөн бөгөөд сургалтын гадаад үр ашиг нэмэгдсэн гэж дүгнэсэн байна.

Мэргэжлийн сургалтын байгууллагыг төгсөж, 2003 онд ажлын байран дээр гарсан төгсөгчдийн ур чадвар “маш муу” байна гэж аж ахуйн нэгжүүдийн 74 хувь нь тайлагнасан бөгөөд ялангуяа мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн үндсэн ур чадварт сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн юм.<sup>13</sup>

Дээрх судалгаанаас үзэхэд мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээтэй уялдуулж эрэлтийг тодорхойлохгүй байгаа

<sup>12</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017.

<sup>13</sup> Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ. 2019

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

нь хөдөлмөрийн зах зээл дээр үүссэн мэргэжилтэй ажилтны хомсдол, ажлын байрны хүртээмжийн зөрүүнээс харагдаж байна.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ:*

**16 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ**

Үнэлэх хэсэг	<p>16.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.</p> <p>16.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"><li>- <i>Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээний одоогийн тогтолцоо хангалттай түшинд хэрэгжиж байгаа эсэх?</i></li><li>- <i>Сургалтын чанарын үнэлгээг бодитой тогтоож чадаж байна уу?</i></li></ul>

Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.", 16.3-т "Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно." гэж тус тус заасан.

ХНХЯ-ны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн 2020 онд хийсэн "Политехникийн зорилтот мэргэжлийн төгсөгчдийн мөшгих судалгаа ба ур чадварын зөрүүг тодорхойлох нь" судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцсон 398 төгсөгчдийн 64 хувь нь "энэ ажлын байрандаа тогтвортой ажиллах бодолгүй байна гэж хариулсан бол тухайн ажлын байрандаа тогтвортой ажиллах бодолгүй байгаагийн шалтгааныг судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 30.6 хувь нь мэргэжил, мэдлэг, ур чадварт тохирохгүй байна." гэж хариулсан байна.

Мөн Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ /2019/-д дурдснаар мэргэжлийн сургалтын байгууллагыг төгсөж, 2003 онд ажлын байран дээр гарсан төгсөгчдийн ур чадвар "маш муу" байна гэж аж ахуйн нэгжүүдийн 74 хувь нь тайлагнасан бөгөөд ялангуяа мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн үндсэн ур чадварт сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн байна. RAND корпорацаас явуулсан судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ТМБС-ын хөтөлбөр дэх дадлагын сургалтууд (тухайлбал барилга, уул уурхай, болон бусад худалдааны салбарт нэн чухал ач холбогдолтой хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт) хангалттай биш байна гэж үзсэн.<sup>14</sup>

Мэргэжлийн боловсролыг батлагдсан стандарт, хөтөлбөрийн дагуу эзэмшиж төгссөн иргэдийн 30.6 хувь нь мэдлэг, ур чадвар тохирохгүй байгаа шалтгаанаар ажил эрхлэх сонирхолгүй байгаа нь сургалтын чанарын үнэлгээг бодитой тогтоож чадахгүй байгааг илтгэж байгаа төдийгүй хөндлөнгийн чанарын үнэлгээг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

<sup>14</sup> Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ. 2019

Зураг 4. Мөшгих судалгаанд хамрагдагчдын ур чадварын зөрүү



Дээрх мөшгих судалгаанд хамрагдагчдын 73.3 хувь нь өөрийн эзэмшсэн ур чадвараа хангалттай гэж үнэлсэн бол үнэлгээнд хамрагдсан 144 төгсөгчийн 81 нь буюу 56 хувь нь чадамжтай гэж хөндлөнгийн үнэлгээгээр үнэлсэн байна. Эндээс ур чадварын зөрүүг 17.3 хувиар зөрүүтэй гэж үнэлсэн байна.

МБС-ын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар МБС-ын суралцагчдын ур чадвар, чадамжийг сургалтын байгууллага болон МБС-ын Үнэлгээний төв үнэлэх чиг үүрэгтэй. Иймээс МБСБ нь мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийг бүрэн дуусгасан иргэнд гэрчилгээ болон диплом олгож, богино хугацааны сургалтаар эзэмшсэн ур чадвар, чадамжийг МБС-ын Үнэлгээний төвөөс эрх авсан үнэлгээчид тусгайлан боловсруулсан шалгуурын дагуу үнэлэх ба МБСБ-аас олгосон чадамжийн гэрчилгээг бүртгэлжүүлэх ажлыг мөн МБС-ын Үнэлгээний төв гүйцэтгэж байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын “Үнэлгээний төв”-ийг байгуулан ажиллуулах болсон нь үнэлгээг хөндлөнгийн бодитой болгоход чиглэсэн бөгөөд тодорхой үр дүнгүүд гарч байгааг дурдах хэрэгтэй.

Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа ба хөндлөнгийн буюу ажил олгогчийг үнэлгээнд татан оролцуулах нь үнэлгээ илүү бодитой, үр дүнтэй болж улмаар төгсөгчийн ур чадвар сайжрах нөхцөлийг бий болгоно гэж үзэж байна.

Сургалтын үнэлгээтэй холбоотой гардаг бас нэг асуудал бол гадаад, дотоодод мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөртэй дүйцэхүйц албан болон албан бус сургалтын хэлбэрээр мэргэжил эзэмшсэн хүнийг хэрхэн үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх зохицуулалт дутмаг гэж мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалт болон судалгааны материалуудад ихээр дурдагдаж байна. Тухайлбал, иргэд гадаадад ажил хөдөлмөр эрхлэх явцдаа албан бусаар мэргэших, мэргэжил эзэмших нь ихэсч байгаа бөгөөд тэд мэргэжлийн үнэмлэхгүйгээсээ болоод эх орондоо хөдөлмөр эрхэлж чадахгүй байх тохиолдол нийтлэг болсон.

Зөвхөн сүүлийн 3 жилийн байдлаар ХНХЯ-д 297 иргэн хандсаны 60 орчим хувь нь гадаадад ижил түвшний мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгссөн бөгөөд Монгол Улсын политехник коллежийн дипломтой адилтгах боловсролын баримт бичиг авах хүсэлтэй иргэд байсан бол ХХҮЕГ-т хандсан 134 иргэний 30-40 хувь нь гадаадад албан болон албан бусаар ажиллаж мэргэжил эзэмшээд шинээр үнэлгээ хийлгэж үнэмлэхтэй болох иргэд байсан.

Сүүлийн 3 жилд мэргэшлийн түвшин, зэрэг дэв, мэргэжлийн ур чадвараа үнэлүүлэх, батагаажуулах, гэрчилгээжүүлэхтэй холбоотой 1400 гаруй өргөдөл гомдол, санал, хүсэлт, шүүмж ирсэн<sup>15</sup> байна.

<sup>15</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

Сургалтын чанар, үнэлгээтэй холбоотой хөндөгддөг бас нэгэн асуудал бол үйл ажиллагааны чанарыг баталгаажуулахад чиглэсэн сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн тухай асуудал юм. Хуулинд магадлан итгэмжлэлийн тухай зохицуулалтыг тусгаагүй тул сургалтын байгууллагууд өөрсдийн сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргадаг.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж өөрийн үйл ажиллагаандаа дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулах үйл ажиллагаа бол магадлан итгэмжлэл юм. МБСБ-ын магадлан итгэмжлэлийг 2002 оноос БМИҮЗ эхлүүлсэн ч хөндлөнгийн бие даасан хяналт, үнэлгээний энэ байгууллага 1998 онд байгуулагджээ, өнөөг хүртэл МБСБ-аас анх удаагаа 12, хоёр дахь удаагаа 5, харин эрүүл мэнд, технологийн чиглэлийн 7 хөтөлбөр БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдээд байна.<sup>16</sup>

БМИҮЗ-ийн жилийн тайлангуудаас дүгнэлт хийхэд Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын яамнаас тусгай зөвшөөрөл авч сургалт явуулдаг 19 боловсролын байгууллага магадлан итгэмжлэл хийлгэснээс хувийн их дээд сургууль 8, төрийн их дээд сургууль 4, Политехник коллеж 7 “байгууллагын магадлан итгэмжлэл” хийлгэж байсан байна.<sup>17</sup>

Хүснэгт 1. Сургалтын ангилал

№	Сургалтын ангилал/ хугацаа	Мэргэжлийн сургалт		Мэргэжлийн боловсрол		Техникийн боловсрол	
		Чадамжид суурилсан сургалт	Мэргэшүүлэх сургалт	1 жил	2.5 жил	1.5 жил	3 жил
1	Сургалтын хөтөлбөрийн тоо	298	107	348	172	181	99
2	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	0	0	0	3	2	2
3	Хувиар	0%	0%	0%	0.01%	0.01%	0.02%

Сүүлийн жилүүдэд МБСБ нь ISO9001 болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандартын дагуу дотоодын чанарын баталгааг хангах чиглэлээр МБСБ-ын удирдах ажилтнуудад зориулсан сургалтыг Сингапурын политехник коллеж ба Темасек сангийн санхүүжилттэй төслөөр хэрэгжүүлсэн байна.

Монголын МБС-ын хөтөлбөрийг чанарын судалгааны системд шилжүүлэх ажил үргэлжилж онол 30 хувь нь дадлага 70 хувь гэсэн агуулгаар шинэ хөтөлбөр боловсруулагдаж байна. Чанарын судалгааны системийн талаарх мэдлэг ойлголт өгөх эрчимжүүлсэн сургалтыг сүүлийн 10 жилд 1500 гаруй багш нарт явуулсан байна.

*Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг:*

**17 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг**

Үнэлэх хэсэг

17.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах эрхтэй.  
17.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;

<sup>16</sup> Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ. 2019

<sup>17</sup> Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2016 оны тайлан [www.accmon.mn](http://www.accmon.mn)



*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

Томьёолсон шалгуур үзүүлэлт

- *Хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?*

Суралцагчийн эрх, үүрэгт хамааралтай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т “үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга М.Нямсүрэнгээс 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр энэ заалтын хэрэгжилтийн талаар утсаар тодруулахад “МБС-ын орчны стандартын хяналт л хийдэг. 17.1.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд боловсролын хяналтын улсын байцаагч ногдуулсан шийтгэл байхгүй” гэж хариулсан.

Мөн ХНХЯ-ны Мэргэжлийн боловсролын сургалтын салбар хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын үеэр сургалтын байгууллага, ажил олгогчтой байгуулсан гэрээний дагуу явагддаг тул манай дээр бүртгэлтэй тоо баримт байхгүй байна, албан бус мэдээлэл учраас савлагаа ихтэй байдаг ба Хөдөлмөрийн хуультай зөрчилддөг заалт байгаа” гэж хариулсан.

*Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш:*

**18 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш**

Үнэлэх хэсэг

18.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.  
18.2. Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

Томьёолсон шалгуур үзүүлэлт

- *Мэргэжлийн сургалтын байгууллагын багшийн чадвар, чадамжийг үнэлэх тогтолцоо бий эсэх?*  
- *Багшийг чадавхижуулах, хөгжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг эсэх, сургалтын үр дүнг хэрхэн хэмждэг вэ?*

Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна”, 18.2-т “Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна” гэж заасан. Мөн мэргэжлийн боловсролын сургалтын багш нь шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтандаа эдгээрийг хэрэглэх үүрэгтэй болохыг хуульчилсан.

Мэргэжлийн боловсролын сургалтын төгсөгчдийн ур чадвар нь багшийн ур чадвараас ихээхэн хамаардаг бөгөөд багшийг чадавхижуулах, мэргэшүүлэх нь мэргэжлийн боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэхэд хамгийн чухал үүрэгтэй төдийгүй багшийг тасралтгүй хөгжүүлэх, чадавхижуулах асуудал хамгийн ихээр хөндөгдөж байна.

2017 онд олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр давхардсан тоогоор ажил олгогч компаниудын 273 ажилтныг дадлагажуулагч багшаар бэлтгэж, үйлдвэрлэлийн сургалтын 123 багш, үнэлгээний 76 багш, төрөл бүрийн түгээн дэлгэрүүлэх сургалтад 1629 багш, ажил олгогч, 650 удирдах албан тушаалтныг мэргэшил дээшлүүлэх сургалт болон ур чадвар, хүний хөгжлийн гадаад, дотоодын сургалтад хамруулж чадавхижуулсан байна. Харин

2018 оны I-V сард донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2100 багш, удирдах ажилтныг дахин чадавхжуулжээ.<sup>18</sup>

МБС-ын байгууллагууд нь тухайн мэргэжлээрээ мэргэшсэн ажилтнуудыг багшаар ажилд авдаг бөгөөд тэд бүсийн арга зүйн төвүүд дээр богино хугацааны сургалтад хамрагдан багшлах эрхтэй болдог байна. Бүсийн арга зүйн төвүүд нь багш нарт сургалт зохион байгуулах, хөтөлбөр хөгжүүлэлтийг арга зүйгээр хангадаг гол байгууллага юм. Сүүлийн жилүүдэд хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр зөвхөн МБС-ын багш бэлтгээд зогсохгүй үйлдвэрлэлийн сургалтын багш бэлтгэх ажиллагаа өргөжсөн гэж ЮНЕСКО-гоос 2019 онд хийсэн “Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ”-нд дурдсан байна.

Энэхүү тойм шинжилгээний зөвлөмжид мэргэжлийн боловсролын сургалтын багш, хүний нөөцийг бэлтгэх, чадахуулахтай холбоотой “МБС-ын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг Их, дээд сургуулиуд дээр хэрэгжүүлэх боломжийг бодолцож үзэх; МБС-ын багш, сурагчдад ажлын байранд шаардлагатай чадварууд, практик үр чадваруудыг эзэмшүүлэх” гэсэн зөвлөмжийг өгсөн байдаг.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн удирдлагатай хийсэн уулзалтын үеэр багш, мэргэжилтнийг чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж буй хэдий ч зарим талаар хангалттай үр дүн гарахгүй байгаа талаар дурдаж байсан.

### 2.3. “Зардал, үр өгөөжийн харьцаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг хэрэгжүүлснээр нийгэмд ямар үр нөлөө үзүүлсэн бэ? Хуулиар дэвшүүлсэн зорилтдоо хүрсэн үү үгүй юу гэдгийг тодорхойлох зорилгоор хуулийн зардлыг тооцсон. Ийнхүү зардал тооцоход Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ыг удирдлага болгосон.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

МБС-ын тухай хуулийн төрийн байгууллагад үүсгэсэн зардыг дараах байдлаар тус тус тооцож, хялбарчлах боломжийг шалгав. Үүнд:

1. Тухайн этгээдийн гүйцэтгэх үүрэг;
2. Зардал;
3. Тоон үзүүлэлт;
4. Нийт зардлын дүн;
5. Нэмэлт зардал.

Хүснэгт 2-оор МБС-ын тухай хуульд байгаа зардал шаардлагатай зохицуулалтуудыг харуулахыг зорьлоо.

д/д	Хуулийн зохицуулалт	Зардал шаардлагатай заалт	Хамаарах этгээд		
			Захиргаа	Хуулийн этгээд	Иргэн
1	6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд	6.3.1.мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт гаргах; 6.3.2.ажиллах хүчний талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил	+		
			+		

<sup>18</sup> Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. /ХНХ-ийн сайд С.Чинзоригийн хэлсэн үгнээс/. БСШУЯ, 2019.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	<p>удирдлагыг хэрэгжүүлнэ. 6.3.Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>олгогчид, яамдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; <i>/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p> <p>6.3.3.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх талаар мэдээлэл, илтгэл хэлэлцэх, тогтоол, зөвлөмж гаргах, чиглэл өгөх; <i>/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i> <i>/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p> <p>6.3.4.улсын хэмжээнд мөрдөх ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах; <i>/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>6.3.5.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;</p> <p>6.3.6.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг судалж, санал гаргах;</p> <p>6.3.7.гаргасан шийдвэр, зөвлөмжийнхээ хэрэгжилтэд хяналт тавих.</p> <p>6.3.8.ажил олгогч болон салбар зөвлөлийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлах батлах.</p>			
2	<p>6.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална. <i>/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i> <i>/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>		+		
3	<p><b>7 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b></p> <p>7.1.Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн, түүнчлэн бусад төрийн захиргааны төв байгууллага хуулиар тогтоосон эрхлэх асуудлын чиглэлээр энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийг бодлогоор дэмжиж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.</p>		+		
4	<p><b>8 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх</b> <i>/Энэ зүйлийн гарчигт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийг хуулиар нэмэлт оруулсан/</i></p> <p>8.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.</p>		+		
5	<p>8.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ. <i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p>		+		
6	<p>8.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<p>8.4.1.мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;</p>	+		

**Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан**

<p><i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ /Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>	8.4.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;	+		
	8.4.3.мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;	+		
	8.4.4.төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах талаар дүгнэлт гаргах; <i>/Энэ заалтад 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>	+		
	8.4.5.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;	+		
	8.4.6.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хүний нөөц, суралцагчдын нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтэд зохицуулалт хийх;	+		
	8.4.7.сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшлийг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	+		
	8.4.8.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, ангиллыг тогтоох;	+		
	8.4.9.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах	+		
	8.4.10.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах; <i>/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i>	+		
	8.4.11.мэргэжлийн үр чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах;	+		
	8.4.12.мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи статистик болон бусад мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сан бүрдүүлэх, хөтлөх;	+		
	8.4.13.төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, ажлын байрын тодорхойлолтыг батлах; <i>/Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийг хуулиар нэмэлт оруулсан/</i>	+		

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	8.4.14.төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;	+		
	8.4.15.мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар шаардлагатай мэдээ тайлан, тооцоо судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;	+		
	8.4.16.мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар олон улсын гэрээ, конвенци, хэлэлцээрээр Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, зохицуулах;	+		
	8.4.17.мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр хийгдэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хариуцуулан гүйцэтгүүлэх талаар судлах, санал боловсруулах;	+		
	8.4.18.энэ хуулийн 8.4.17-д заасан чиглэлээр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гаргах;	+		
	8.4.19.мэргэжлийн сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах;	+		
	8.4.20.мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоодын оролцоотойгоор ажил, мэргэжил, ур чадварын стандарт боловсруулах, модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах.	+		
	8.4.21.мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах; <i>/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>	+		
	8.4.22.мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийн болон бүсийн арга зүйн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг баталж, менежерийг томилох, чөлөөлөх; <i>/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/</i> <i>/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i>	+		
	8.4.23.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.	+		
7	8.5.Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын хэрэгжилтийг хангах,	+		

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

	чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалт, судалгаа эрхлэх чиг үүрэгтэй байна. <i>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>			
8	10.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын загварыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу баталж, улсын бүртгэлд бүртгэнэ. <i>/Энэ хэсэгт 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</i>	+		
9	12.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрөл авсан байх бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна.	+	+	
10	12.9.Мэргэжлийн сургалтыг зохих зөвшөөрөл авсан сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэн зохион байгуулж болно. <i>/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i>		+	+
11	12.10.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төлөөлөлд ажил олгогчийн төлөөлөл байх ба удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i>	+		
12	13.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. <i>/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>	+		
13	14.1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна.	+		
14	14.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулах ба тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i> <i>/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>	+		
15	14.5.Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	+		
16	15.2.Техникийн боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.			+
17	15.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоо, элсэлтийн үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага батална.	+		
18	15.4.Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана. <i>/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i>	+		
19	16.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.	+	+	

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

11	16.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчид дараахь бичиг баримт олгоно:	+		
12	16.8.Энэ хуулийн 16.4-т заасан бичиг баримтын загвар, бичиг баримт бүрдүүлэх, олгох журмыг Зөвлөлийн саналыг үндэслэн хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. <i>/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>	+		
13	16.9.Үнэлгээ, мэдээллийн төв энэ хуулийн 16.1-д заасан журмыг хэрэгжүүлж, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах, төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэлт гаргах, ном сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. <i>/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/</i>	+		
14	17.3.Энэ хуулийн 17.1.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох шийтгэлийг боловсролын хяналтын улсын байцаагч ногдуулна.	+		
15	18.5.Энэ хуулийн 18.4-т заасан багшийн цалин, нэмэгдэл хөлс олгох журмыг санхүүгийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран, харин ажлын байрны тодорхойлолт, сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам, аргачлал, зөвлөмжийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална. <i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i> <i>/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>	+		
16	18.7.Багшлах эрх, энэ хуулийн 18.6-д заасан зэрэг олгох, хасах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i>	+		
17	19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.	+	+	
18	<b>21 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилт</b> 21.1.Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. <i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i>	+		
19	21.2.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.	+		
20	24.1.Улсын төсвөөс тухайн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд олгох хөрөнгийн хэмжээг Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална.	+		
21	24.2.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.	+		
22	24.3.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл батална.	+		
23	25.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж, энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл болон хөдөлмөр, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ирүүлнэ:	+		

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	<i>/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ /Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>			
24	26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.	+		
	<b>Нийт</b>	<b>60</b>	<b>4</b>	<b>2</b>

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудалд байхаар хуульчлагдсан. Тус яамнаас төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хийсэн чиг үүргийн шинжилгээгээр Мэргэжлийн боловсрол сургалтыг 13 дэд чиг үүргээс бүрдсэн үндсэн чиг үүрэг байна гэж томъёолсон байдаг.<sup>19</sup>

Чиг үүргийн шинжилгээ хийсэн ажлын хэсгээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад 2018 онд батлагдсан төсвийн зарцуулалтад шинжилгээ хийгээд батлагдсан төсвийн 1,7 хувь буюу 57,8 тэрбум төгрөгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулсан гэж тооцсон байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судлахад ХНХЯ-ны энэ үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх субъект нь төрийн байгууллагууд байна.

Иймд зардлын тооцоог хийхдээ төрийн байгууллагаас зардал шаардсан дараах 3 зохицуулалтыг сонгож авсан.

- 12.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрөл авсан байх бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна.
- 16.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчид дараахь бичиг баримт олгоно:
- 19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.

Зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төрийн захиргааны төв байгууллагын бодлого боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцдоггүй.

Зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Төрийн байгууллагад үүрэг болгосон ажил, үйлчилгээг хийхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээ хэд байх вэ гэдгийг тогтоохдоо:

1. Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудаас тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацааны зарцуулалт шаардагдах эсэхийг тодорхойлох;
2. Тухайн ажил үйлчилгээ хэдэн удаа хийгдэх буюу тохиолдлын тоог тооцон гаргах шаардлагатай.

<sup>19</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэг дахин хуваарилах шинжилгээний тайлан, ХНХЯ-2019



*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

Төрийн захиргааны байгууллагын ажилтнуудаас тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацааны зарцуулалт шаардагдахыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны загварыг<sup>20</sup> ашиглана.

Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц түүнд шаардагдах зардлыг тооцсон. Үүний тулд үнэлэхээр сонгож авсан зохицуулалтын хувьд гүйцэтгэх захиргааны үүрэг болон стандарт үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойллоо:

**Хүснэгт 3. Гүйцэтгэх захиргааны үүрэг болон стандарт үйл ажиллагааны зардлын тооцоо**

<b>№</b>	<b>Хуулийн зохицуулалт</b>	<b>Үүргийг гүйцэтгэх байгууллага</b>	<b>Гүйцэтгэх үүрэг</b>	<b>Тухайн үүргийг гүйцэтгэх стандарт үйл ажиллагаа</b>
1.	12.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь <b>тусгай зөвшөөрөл авсан байх</b> бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна. <sup>21</sup>	Төрийн байгууллага	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох	-Баримт бичиг хүлээн авах -Баримт бичгийг нягтлах -Ажлын хэсгийн саналыг судлах -Саналыг нэгтгэж дүгнэлт гаргах -Тусгай зөвшөөрөл олгох
2.	16.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчид дараахь бичиг баримт олгоно. <sup>22</sup>	Төрийн захиргааны төв байгууллага <sup>23</sup>	Төгсөгчдөд мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ, боловсролын гэрчилгээ <sup>24</sup> олгох	-Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний захилга авах /сургуулиудаас ирүүлсэн цахим баримтыг шалгах/ - Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний захилга авах -Мэргэжлийн диплом, үнэмлэх гэрчилгээнд бичилт хийх, баталгаажуулах -мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгосон тухай тайлан мэдээ гаргах

<sup>20</sup> Хууль тогтоомжийн тухай хууль – Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016, ху 243-245

<sup>21</sup> МБС-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэг нь мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулах ба тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасантай уялдаатай хэрэгжихээс гадна хуулийн энэ зохицуулалтыг хэрэгжүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018.05.04-ний өдрийн А/104 тушаалаар баталсан. “Шаардлага загвар батлах тухай” А/104 дүгээр тушаал нь ЗХХА-ын бүтгэлд 2018-05-21-ны өдөр 3907 дугаартайгаар бүртгэгдэж, ЗХХА-ын эмхэтгэлийн 2018 оны № 17 дугаарт нийтлэгдсэн байна.

<sup>22</sup> МБС-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэхээр “Журам, загвар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019.08.13-ны А/505, А/267 дугаар тушаал батлагдсан. Энэ тушаал нь ЗХХА-ын бүртгэлд 2019-08-23-ны өдөр 4453 дугаартайгаар бүртгэгдэж, ЗХХА-ын эмхэтгэлийн 2019 оны № 26 дугаарт нийтлэгдсэн байна.

<sup>23</sup> “Журам, загвар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019.08.13-ны А/505, А/267 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журам”-ын 2.1 дахь хэсэгт “Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг бүрэн эзэмшсэн төгсөгчдөд Мэргэжлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн диплом олгоно”, 2.2 дахь хэсэгт “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцан мэргэжил эзэмшихийн зэрэгцээ бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсролын үнэмлэхийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран олгоно.” гэж тус тус заасан байна.

<sup>24</sup> МБС-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2, 16.4.3 дахь заалтад төрийн байгууллага МБС-ын байгууллагад суралцаж төгссөн хүнд ямар бичиг баримт олгохыг тодорхой заасан.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

3.	19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний <b>мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.</b> <sup>25</sup>	-Төрийн өмчит Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон техникийн коллеж;	-ажиллаж байгаа багшид 5 жил тутамд нэг удаа 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	-Тухайн багшаас 5 жил ажилласан тухай тодорхойлолтыг хүсэлтийн хамт хүлээж авна. -Ирүүлсэн баримт бичгийг нягтлах -Тодорхойлолт, хүсэлтэд үндэслэлд төсвийн төсөөлөлд оруулахаар тооцоо хийнэ. /5 жилийн цалингийн дунджийг гаргана. Төсвийн төсөөлөлд тусгана./ -Батлагдаж ирсний дараа олголт хийнэ. /татвар, шимтгэл тооцохгүй тул шууд олгоно/
----	--	--	--	---

**Тайлбар:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018.05.04-ний өдрийн А/104 тушаалаар баталсан “Шаардлага загвар батлах тухай” А/104 дүгээр тушаалд “Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагууд, хяналт, шинжилгээ, үнэлгээний байгууллага зэрэг төлөөллөөс бүрдүүлж, Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэсэн байна. Иймд тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой тусгайлан томилогдсон албан хаагч байхгүй боловч төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ажилладаг учраас төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцно.

Хуулиар тогтоосон дээрх үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тооцохдоо шаардагдах тохиолдлын тоон утгыг дараах байдлаар тооцсон. Үүнд:

А.Гүйцэтгэх үүрэг 1: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бэлтгэсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээлэл /2018-2019 оны хичээлийн жил/ эмхэтгэлээс авсан. Уг статистикийн эмхэтгэлд мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын 2011 оноос хойших мэдээлэл багтсан бөгөөд төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцохдоо 2011-2019 он хүртэл төрийн өмчийн МБСБ 7 жилийн хугацаанд 7 байгуулагдсан байна.

**Тохиолдлын тоо жилд 1 гэж үзнэ.**

Б. Гүйцэтгэх үүрэг 2:

Хүснэгт 4.Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын нийт төгсөгчдийн тоо /2011-2018/

д/д	Он	Төгсөгчдийн тоо	Хөдөлмөр эрхлэлтийн хувь	Хөдөлмөр эрхлэлт
1	2011/2012	23120		Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 2019-2020 оны хичээлийн жилийн төгсөгчдийн ажлын байртай болсон талаар статистик мэдээнээс харахад нийт 18.887 төгсөгчдөөс 51.5% буюу 9.724 төгсөгч төгсөнгүүтээ шууд хөдөлмөр эрхэлж байна.
2	2012/2013	23393	61.6%	
3	2013/2014	18358		
4	2014/2015	18978	32.8%	
5	2015/2016	19488		
6	2016/2017	19531		
7	2017/2018	20544		
8	2018/2019	21206	58.1%	

<sup>25</sup> МБС-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг нь 2002.05.03-ны өдөр батлагдан хэрэгжиж байгаа Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасантай давхардан хэрэгждэг.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан

9	2019/2020	18887	51.4%	<b>Тайлбар:</b> Хөдөлмөр эрхлэлтийн хувь ямар байгаа талаар жил бүрийн мэдээлэл бүрэн гарсан тайлан мэдээлэл гараагүй.
---	-----------	-------	-------	--

Гүйцэтгэх үүрэг 2-ын хувьд тохиолдлын тоо: нийт 9 удаагийн төгсөгчийн тооны нийлбэрийг төгссөн тохиолдолд хувааж олсон.

**Тохиолдол:20389,44** байна.

В.Гүйцэтгэх үүрэг 3:МБС-ын тухай хуулийн 19.3 дахь хэсэг нь Боловсролын тухай хуулийн дараах зохицуулалттай давхар хэрэгждэг. Үүнд:

**43 дугаар зүйл.Боловсролын харилцаанд оролцогчдын нийгмийн баталгаа**

43.1.Багш нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:

43.1.1.хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авах, хуульд заасан бусад хөнгөлөлт эдлэх;

43.1.2.багш, ажиллагчдын ээлжийн үндсэн амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.5, 79.6-д заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

43.1.3.орон сууц барих буюу худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламж авах;

43.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгах;

*/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль, 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/*

43.1.5.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багшид нэмэгдэл цалин, урамшил, бусад дэмжлэг үзүүлэх;

*/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

43.1.6./Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

43.1.7.Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох:

43.1.7.а.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч;

43.1.7.б.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш.

*/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

43.1.8.ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох;

*/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

43.1.9.хуульд заасан бусад баталгаа.

*/Энэ заалтын дугаарт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн санхүүгийн мэдээлэлд тулгуурлаж дараах тооцоог хийв.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

**Хүснэгт 5.Нэг удаагийн тэтгэмжийн тооцоо**

д/д	Нэг удаагийн тэтгэмжийн төрөл	2016 он		2017 он		2018 он	
		Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/
1	МБС-ын тухай хуулийн 19.3-т зааснаар 5 жил тутам 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж	345	2,145.3	226	1,342.3	210	1,397.7
2	Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасны дагуу нэг удаагийн тэтгэмж	35		15		29	

2016-2018 онд нийт 760 багш тэтгэмж авсан бөгөөд 3 жилийн дундаж нь 253 байна. Иймд тохиолдлын тоог энэ **3 жилийн дундаж утгаар 253 гэж авлаа.**

Дээрх тохиолдлын тоог харгалзан шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар тооцно.

**Хүснэгт 6.Хүний нөөцийн хэрэгцээний задлын тооцоо**

д/д	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо /дундаж утгаар/	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох	-Баримт бичиг хүлээн авах	15	1	1	15
		-Баримт бичгийг нягтлах	30	1	1	30
		-Ажлын хэсгийн саналыг судлах	30	1	1	30
		-Саналыг нэгтгэж дүгнэлт гаргах	20	1	1	20
		-Тусгай зөвшөөрөл олгох	15	1	1	15
		-Холбогдох байгууллагад хүргүүлэх	40	1	1	40
2	Төгсөгчдөд мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ, боловсролын гэрчилгээ	-Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний захилга авах /сургуулиудаас ирүүлсэн цахим баримтыг шалгах/	15	20389	1	305835
		- Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний захилга авах	20	20389	1	407780
		-Мэргэжлийн диплом, үнэмлэх гэрчилгээнд бичилт хийх, баталгаажуулах	7	20389	1	142723
		-мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгосон тухай тайлан мэдээ гаргах	60	20389	1	1 223 340
3	Ажиллаж байгаа багшид 5 жил тутамд нэг удаа 10 сарын цалинтай тэнцэх	-Тухайн багшаас 5 жил ажилласан тухай тодорхойлолтыг хүсэлтийн хамт хүлээж авах	10	253	1	2530
		-Ирүүлсэн баримт бичгийг нягтлах, хувилах	15	253	1	3795

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	-Тодорхойлолт, хүсэлтэд үндэслээд төсвийн төсөөлөлд оруулахаар тооцоо хийнэ. /5 жилийн цалингийн дунджийг гаргана. Төсвийн төсөөлөлд тусгана.	20	253	1	5060
	-Батлагдаж ирсний дараа олголт хийнэ. /татвар, шимтгэл тооцохгүй тул шууд олгоно/	8	253	1	2024
<b>Нийт зарцуулах хугацаа</b>					<b>2 093 237 мин</b>

Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзвэл 1 жилд ажиллах ажлын өдөр 200 /Хуанлийн 365 хоногоос нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, 7 хоногийн амралтын өдрүүдийг хасч тооцсоноор/

Өдөрт ажлын 8 цаг бөгөөд 200 ажлын өдөрт 1600 цаг буюу үүнийг минутад шилжүүлбэл /1600\*60/ 96000 минутыг жилдээ ажиллахад зарцуулна. Тэгвэл төрийн захиргааны байгууллага дээрх үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөц нь:

Хэрэгжүүлэх байгууллага	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ачаалал
Төрийн байгууллага	2 093 237	96 000	21

Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын мэдээллийн үндсэн дээр гаргадаг бөгөөд ажиллах шаардлагатай хүний нөөцтэй тэдгээр зардлын оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардлыг тооцно.

Аргачлалд заасны дагуу тооцоо хийхдээ албан ёсны эх сурвалжаас авсан тоо баримтад тулгуурлах ёстой тул нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн хувьсах зардал болон материаллаг зардлын талаар одоо хүчин төгөлдөр хэвээр байгаа Монгол Улсын Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоолыг судлахад “Орон нутагт оршин суугаа 1000 хүнд ногдох удирдлагын хувьсах зардлын жишиг нормативыг Улаанбаатар хот 3300 төгрөг”-өөр тогтоосон нь 19 жилийн өмнө батлагдсан жишиг тул ашиглах боломжгүй байв.

Иймд уг ажлыг төрийн байгууллага хариуцан гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг гаргаснаар тооцоолол дуусахаар байсан ч мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас шаардлагатай мэдээллийг цуглуулснаар зардлыг тооцон гаргах боломжтой болсон.

**Хүний нөөцийн зардал:** Төрийн байгууллагын зардлын дийлэнхийг хүний нөөцийн зардал эзэлдэг. Тодруулбал тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бүх зардлыг энд тооцно. Эдгээрийг нэгтгэн дундажаар гаргасан зардалыг хүний нөөцийн зардал гэх бөгөөд үүнийг дараах байдлаар томъёолон үзүүлж болно.

Томьёо-1

<p><b>Хүний нөөцийн буюу боловсон хүчний дундаж зардал</b></p> <p align="center">=</p> <p align="center">Шууд зардал + Нийтлэг зардал + Дагалдах зардал+ Нэмэгдэл зардал</p>
--

МБС-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан дээрх үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хувьд дараах шууд зардлыг төрөөс гаргадаг гэж үзлээ.

Хүснэгт 7. Хүний нөөцийн төрөөс шаардагдах шууд зардлын тооцоо

Байгууллага	Үйл ажиллагаа	Үүрэг хүлээгч	Цалингийн сүлжээний дагуу	Дундаж цалин /төг/
Төрийн захиргааны төв байгууллага	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад тусгай зөвшөөрөл олгох	Ахлах мэргэжилтэн	ТЗ-8, 1-5 шатлал <sup>26</sup> болон ХНХЯ-аас ирүүлсэн 2017-2019 оны цалингаар тооцсон	840082
	Төгсөгчдөд мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ, боловсролын гэрчилгээ олгох	мэргэжилтэн	ТЗ-7, 1-5 шатлал <sup>27</sup> болон ХНХЯ-аас ирүүлсэн 2017-2019 оны цалингаар тооцсон	715721
Төрийн өмчит МБСБ	Ажиллаж байгаа багшид 5 жил тутамд нэг удаа 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	Үйл ажиллагааны ня-бо	ТҮМБ-3-1 -ээр дундаж тооцсон <sup>28</sup>	700895
<b>Нэг албан хаагчийн дундаж цалин</b>				<b>2 256 698</b>

Дээрх хүснэгтэд тухайн чиг үүргийг хүлээж байгаа төрийн байгууллагын ажил үйлчилгээг гүйцэтгэх нэг албан тушаалтанд оногдох зардал гарсан. Энэ зардалыг өмнө нь тооцон гаргасан хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэхэд хүний нөөцийн нийт зардал гарна.

Байгууллага	Нэмэгдэж буй ачаалал	1 албан хаагчийн дундаж цалин	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Төрийн байгууллага	21	2 256 698	47 390 658

Төрийн захиргааны төв байгууллагын цалингийн дундажийг тооцоход Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-г баримталсан. ХНХЯ мэргэжлийн боловсрол, сургалт хариуцсан 10 хүнтэй. Эдгээрээс гүйцэтгэх албан тушаалын 9 хүн байгаа бөгөөд 2 ахлах шинжээч, 2 ахлах мэргэжилтэн, 5 мэргэжилтэн одоогийн байдлаар ажиллаж байна.

Хүний нөөцийн нийт зардал нь **47 390 658** дөчин долоон сая гурван зуун ерөн мянга зургаан зуун тавин найман төгрөг болно.

**Материаллаг зардал:** тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардалыг хэлнэ. Тухайлбал цахилгааны зардал, техник тоног төхөөрөмжийн зардал, бичиг хэргийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал орох бөгөөд бүгд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ. Материаллаг зардал, ажлын байрны зардлын жишээг ХНХЯ-ны нэг ажилтны материаллаг зардлыг тооцсон жишээгээр авав.<sup>29</sup>

Урсгал зардал

– Бичиг хэргийн зардал  $-995983 \times 21 = 20\,915\,643$

<sup>26</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ” – ний ТЗ-9, шатлал 1-5 аас дундаж утгаар тооцсон.

<sup>27</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ” – ний ТЗ-8, шатлал 1-5 аас дундаж утгаар тооцсон.

<sup>28</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮМБ-3, шатлал 1-5 аас дундаж утгаар тооцсон.

<sup>29</sup> ХНХЯ, УБ 2017

**НИЙТ = 20 915 643 төг**

Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал

- Гэрэл цахилгаан - 617278 \*21=12962898
- Цэвэр, бохир ус – 184484\*21=3874164
- Урсгал засвар – 60424\*21=1268904
- Газрын төлбөр – 6590\*21=138390

**НИЙТ = 5 281 458 төг**

Элэгдэл хорогдолын зардал = 5255237\*21= 110 359 977 төг

Дээрх бүгд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Томьёо-2

**Ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал**

=

Урсгал зардал + Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал + Элэгдэл хорогдолын зардал

**20 915 643 + 5 281 458 + 110 359 977 = 136 557 078 төг**

Материаллаг зардлыг 7 079 206 төгрөг гэж тооцлоо.

**Бусад зардал:** Бусад зардалд төрийн байгууллагаас үүрэг биелүүлэхэд буюу ямар нэгэн ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд гарах зардлыг биш, харин тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал хамаарна.

Энэ хуулийн тухайд “19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний **мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.**<sup>30</sup>” заасан тул багшид 5 жил тутамд төсвөөс олгосон тэтгэмжийг нэмэлт зардал гэж тооцно.

Хүснэгт 8.Хуульд 5 жил тутам олгох нэг удаагийн тэтгэмжийн төрлийн зардлын тооцоо

д/д	Нэг удаагийн тэтгэмжийн төрөл	2016		2017		2018	
		Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Багшийн тоо	Гүйцэтгэл /сая.төг/
1	МБС-ын тухай хуулийн 19.3-т зааснаар 5 жил тутам 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж	345	2,145.3	226	1,342.3	210	1,397.7
2	Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасны дагуу нэг удаагийн тэтгэмж	35		15		29	

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс бэлтгэж ирүүлсэн дээрх тайланд дурдсанаас МБСБ-ын багшид олгосон 1 удаагийн мөнгөн тэтгэмжид

<sup>30</sup> МБС-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг нь 2002.05.03-ны өдөр батлагдан хэрэгжиж байгаа Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасантай давхардан хэрэгждэг.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

зориулсан зардлын дунджаар тооцоход нэг багшид 5,5 сая төгрөгийн тусламжийг ойролцоогоор олгосон гэж тооцов.

Хугацаа	Олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн дүн /сая төгрөг/	Тухайн жилд тэтгэмж хүртсэн багшийн тоо	Нэг багшид оногдсон мөнгөн дүн ойролцоогоор /сая төгрөг/	Дундаж утга /сая төгрөг/
2016	2,145.3	380	5,6	5,6
2017	1,342.3	241	5,5	
2018	1,397.7	239	5,8	

**Зардлыг нэгтгэн тооцож гаргах:** Одоо дээр тооцсон зардлуудын нийт дүнг гаргая.

1.	Хүний нөөцийн нийт зардал	<b>47 390 658 төг</b>
+	2. Материаллаг зардал	<b>136 557 078 төг</b>
	3. Бусад зардал	<b>5 600 000 төг</b>
	<b>ЗАРДАЛ</b>	<b>189 547 736 төг</b>

Зардлыг нэгтгэн тооцож гаргахад МБС-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан үүргийг гүйцэтгэхэд 2016-2019 онд зарцуулсан төсвийн дүнгээр баримжаалан тооцоход жилд хамгийн багадаа 60 069 864 төгрөгийг зарцуулан нийт 21 албан хаагч хийж гүйцэтгэжээ гэсэн тооцоо гарч байна. Хууль хэрэгжсэнээс хойш ойролцоогоор 2020 он хүртэл 12 жилийн турш ийм хэмжээний зардал гарчээ гэж баримжаалахад хуулийн зөвхөн дээрх гурван зохицуулалтыг хэрэгжүүлэхэд **189 547 736 /зуун наян ес сая таван зуун дөчин долоон мянга долоон зуун гучин зургаа/ төгрөгийг зарцуулсан байна.**

**Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах:** Ийнхүү хуулийг хэрэгжүүлэхэд ямар зардал гарав, ямар үл нөлөө үзүүлэв гэдгийг тогтоох нь зардал тооцох үнэлгээний зорилго бөгөөд төрийн захиргааны байгууллагад буюу төсөвт дээрх байдлаар зардал гаргасан нь хуулийн зорилгод хүрэх байдалтай хэрхэн уялдав, ямар эерэг өөрчлөлтийг бий болгосон бэ гэдгийг илрүүлэхэд чухал алхам болсон гэж үзэж байна.

Зардал, үр өгөөжийн харьцааг дараах байдлаар дүгнэв. Үүнд:

12.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь **тусгай зөвшөөрөл авсан байх** бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна.

Хууль хэрэгжсэнээс хойш МБСБ-ыг байгуулах тусгай зөвшөөрлийг төрийн өмчийн 7 сургууль авсан байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарсан зардлын хувьд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй боловч нийгэмд эерэг нөлөө үзүүлээгүй. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын 60 орчим хувь нь 10-40 хүртэлх ижил мэргэжлээр давхардуулан сургаж илүүдэлтэй ажилтныг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байна.<sup>31</sup> гэсэн судалгааг салбарын яамнаас хийсэн байна. Мөн 2017 оны байдлаар ажилгүйчүүдийн 66% нь техник мэргэжлийн, тусгай дунд болон дээд боловсролтой иргэд байгаа бол үлдсэн 34% нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой иргэд байна.

<sup>31</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017.



16.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчид дараахь бичиг баримт олгоно

Төгсөгчдөд дараах баримт бичиг олгож байна. Үүнд:

-мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг албан болон албан бус сургалтын хэлбэрээр эзэмшиж, үнэлгээнд тэнцсэн иргэнд мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ;

-суурь боловсрол эзэмшсэний дараа 2.5-аас доошгүй жил суралцаж мэргэжлийн болон бүрэн дунд боловсролыг хамтад нь эзэмшсэн иргэнд энэ хуулийн 16.4.1-д заасан бичиг баримтаас гадна бүрэн дунд боловсролын гэрчилгээ;

-мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар олгох сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ.

Энэ зохицуулалтын хувьд эерэг үр нөлөөтэй.

19.3. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний **мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.**

Мэргэжлийн сургалтын байгууллагыг төгсөж, ажлын байран дээр гарсан төгсөгчдийн ур чадвар “маш муу” байна гэсэн үнэлгээг аж ахуйн нэгжүүд өгсөн бөгөөд ялангуяа мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн үндсэн ур чадварт сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн<sup>32</sup> байдаг. Түүнчлэн үндэсний мэргэжилтэй ажилтныг бэлтгэх асуудал хэрэгцээ шаардлагыг хангахгүй, салбарууд хүний нөөцийн хомсдолд орсноос гадаадаас ажиллах хүч авах квот буурахгүй, гэсэн атлаа гадаад руу ажиллах хүчний шилжилт жилээс жилд өсч байгаа ийм дүр зурагтай байхад төсөвт үргүй зардал, нэмэлт ачаалал үүсгэж, хуулийн энэ заалтыг өөр хуулийн заалттай давхардуулан хэрэгжүүлж байгаа нь оновчтой биш байна.

<sup>32</sup> Монгол Улсын МБС-ын бодлогын дүн шинжилгээ. 2019

**ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**3.1.Үнэлэлт, дүгнэлт:**

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн томьёолол	Дүгнэлт
1	<p><b>6 дугаар зүйл.</b> <b>Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл</b></p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ.</p> <p>6.3.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаа эсэх?</li> <li>- Зөвлөл бүрэн эрх хангалттай хэмжээнд хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх?</li> <li>- Зөвлөл нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх?</li> <li>- Эрх, үүргийг тодорхойлсон хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байна уу?</li> </ul>	<p>Үндэсний болон салбар зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадахгүй байгаа буюу тус зохицуулалтын хэрэгжилт <b>үр дүнгүй</b> байна.</p> <p>Зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дараах хүндрэл байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Зөвлөлийг хууль батлагдсанаас хойш 5 удаа өөрчилсөн. Тогтвортой ажиллаагүй. Учир нь бүх яамдын төрийн нарийн бичгийн дарга нар бүрэлдэхүүнд нь байдаг тул Засгийн газар шинээр байгуулагдах бүрт өөрчлөгддөг.</li> <li>2.Зөвлөлд аж ахуйн нэгж байгууллагуудаас төлөөлөл байхгүй.</li> <li>3.Эрх үүрэг тодорхойлсон хуулийн зохицуулалт практикт нийцээгүй.</li> </ol> <p>Тухайлбал: Салбар зөвлөлүүдтэй байхаар хуульчилсан ч тэдгээрийн эрх үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг зохицуулж, журамлаагүй.Түүнчлэн Зөвлөл хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хэрхэн яаж хэрэгжүүлэхийг хуульчлаагүй тул салбар бүрт харилцан адилгүй ажиллаж байна.</p>
2	<p><b>8 дугаар зүйл.</b> <b>Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх</b></p> <p>8.4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх; 8.4.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой тодорхойлж чадаж байна уу?</li> <li>- Эрэлт хэрэгцээний үндсэн дээр суралцагч элсүүлж, улмаар ажлын байраар хангаж байгаа эсэх?</li> <li>- Ажил олгогчдоос ирсэн захиалгын дагуу элсэгч авч байна уу?</li> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг бэлтгэж чадаж байна уу?</li> </ul>	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх, эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг гаргах гэсэн заалтуудын хэрэгжилт <b>хангалтгүй, үр дүнгүй</b> байна.</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд тухайн жилийн элсэлтээ зохион байгуулахдаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, судалгаа, ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын цөөн тооны захиалга болон сургалтын байгууллагын зүгээс хөдөө, орон нутгаар мэргэжил сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж элсэлтээ авдаг хэдий ч ажиллах хүчний эрэлтийг үнэн бодитоор тодорхойлж чадахгүй байсаар байна.</p> <p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ямар хүрээнд ойлгох, эрэлтийг тоо, чанарын ямар үзүүлэлтээр, ямар субъектүүд хэрхэн тодорхойлох, эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг хэн нэгтгэн гаргаж МБСБ, ажил олгогчид, иргэдэд хүргэх гээд цөөнгүй асуудал шийдэл хүлээж байна.</p>

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

			Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тодорхой мэдээлэл байхгүйгээс болоод МБСБ-ууд эрэлтгүй буюу эрэлт багатай мэргэжлээр элсэлт авах, зөвшөөрөлгүй мэргэжлээр суралцагч элсүүлэх явдал нийтлэг гарч байна.
3	<p><b>12 дугаар зүйл.</b> <b>Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага</b> 12.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн тодорхойлж байна вэ?</li> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгож чадаж байгаа эсэх?</li> </ul>	<p>Мэргэжлийн ур чадвар, ажил олгохтой холбоотой тулгардаг бас нэг бэрхшээл нь мэргэжлийн сургалтын байгууллагууд төвлөрсөн буюу эрэлт хамгийн их байгаа газар байрладаг нь аймаг орон нутагт бий болсон ажлын байрны хэрэгцээ хангагдахгүй байх нэг нөхцөл болж байна.</p> <p>Ажиллах хүчнийг бэлтгэх бодлого, үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлт хэрэгцээтэй холбох механизм бүрдэж, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгоно гэсэн хуулийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн үр дүн гараагүй байна.</p>
4	<p><b>14 дүгээр зүйл.</b> <b>Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх</b> 14.1. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна 14.2. Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олголт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх?</li> <li>- Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг баталсан эсэх?</li> </ul>	<p>Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг батлан мөрдүүлнэ гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.</p> <p>Богино хугацааны сургалтын чанарыг сайжруулах зорилгоор холбогдох дүрэм журмыг сайжруулж МБСБ-ын тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагын урьдчилсан нөхцөлийг хангах болзлыг ахиулсан нь хуулийн зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг сайжруулжээ.</p>
5	<p><b>15 дугаар зүйл.</b> <b>Суралцагч элсүүлэх</b> 15.4. Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн эрэлтийн судалгааг ямар давтамжтай хийдэг вэ?</li> <li>- Эрэлтийн судалгаанд үндэслэн суралцагч элсүүлдэг эсэх?</li> </ul>	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдсан, төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаагүй байна.</p> <p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээлэл ерөнхий байгаагаас элсэлтийг оновчтой төлөвлөх, зохион байгуулахад хүндрэлтэй, мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудал хөдөлмөрийн зах зээлийн</p>

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	<p>асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон эмэгтэй суралцагчдын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлсэн эсэх?</li> <li>- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээтэй уялдуулж эрэлтийг тодорхойлж чадаж байна уу?</li> <li>- Суралцагч хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?</li> </ul>	<p>эрэлтэд төдийлэн нийцэхгүй, оновчтой бус, хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээтэй уялдуулж эрэлтийг тодорхойлохгүй байгаа нь төгсөгчдийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл дээр үүссэн мэргэжилтэй ажилтны хомсдол, ажлын байрны хүртээмжийн зөрүүнээс харагдаж байна.</p> <p>Суралцагч хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа. Тухайлбал: Ажлын байран дээр дадлага хийсэн суралцагч хуульд заасны дагуу ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс авч чадахгүй байгаа. Мөн мөшгөх судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 60 орчим хувь нь төгссөн мэргэжлээрээ ажиллахгүй, ажил олгогчийн тавьсан шалгуурт тэнцэхгүй, ур чадвар дутагдалтай байна гэсэн хариу өгсөн нь тэдний хүсэл, сонирхол, авьяас чадварт нийцээгүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдаагүй байгааг илтгэж байна.</p> <p>Мэргэжлийн боловсролын сургалтын талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас, түүнчлэн ажлын байрны хүрэлцээ, хангамж, суралцах орчин нөхцөл зэргээс шалтгаалж эмэгтэй суралцагчдын болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эзлэх хувь өсөхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгох төв улсын хэмжээнд ганц байна.</p>
6	<p>16.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.</p> <p>16.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээний одоогийн тогтолцоо хангалттай түшинд хэрэгжиж байгаа эсэх?</li> <li>- Сургалтын чанарын үнэлгээг бодитой тогтоож чадаж байна уу?</li> </ul>	<p>Мэргэжлийн боловсрол сургалтын “Үнэлгээний төв”-ийг байгуулан ажиллуулах болсон нь үнэлгээг хөндлөнгийн, бодитой болгоход чиглэсэн бөгөөд тодорхой үр дүнгүүд гарч байгаа ч дараах хүндрэл бэрхшээл байна. Үүнд:</p> <p>Гадаадад ажил хөдөлмөр эрхлэх явцдаа албан бусаар мэргэших, мэргэжил эзэмших нь ихэсч байгаа бөгөөд тэд мэргэжлийн үнэмлэхгүйгээсээ болоод эх орондоо хөдөлмөр эрхэлж чадахгүй байх тохиолдол нийтлэг байна.</p> <p>БМИҮЗ-ийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг тус тус баталсан. Сургалтын хөтөлбөрийн болон байгууллагын магадлан итгэмжлэлд цөөн тооны сургалтын байгууллага хамрагдсан байна.</p> <p>Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлын үнэлгээ бодит байдалд нийцээгүй, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодитой үнэлгээ болж чадахгүй байгааг илтгэж байгаа ба хөндлөнгийн чанарын үнэлгээг нэвтрүүлэх шаардлага байгааг харуулж байна.</p>

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

7	<p>17.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах эрхтэй.</p> <p>17.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;</p>	<p>Суралцагч хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх эрхээ эдэлж чадаж байгаа эсэх?</p>	<p>Суралцагчийн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж байна.</p> <p>Суралцагчийн хөдөлмөрлөх эрх ашгийг нь хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үйлчлэлийн үр нөлөөг баталгаатай болгох гэсэн уг хуулийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилт хангагдаагүй гэж үзэж байна.</p>
8	<p>18.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p> <p>18.2. Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн сургалтын байгууллагын багшийн чадвар, чадамжийг үнэлэх тогтолцоо бий эсэх?</li> <li>- Багшийг чадавхжуулах, хөгжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг эсэх, сургалтын үр дүнг хэрхэн хэмждэг вэ?</li> </ul>	<p>Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх, үйлдвэрлэлийн туршлагатай мэргэжилтнийг сургалтын ажилд оролцуулах замаар мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, өгөөжийг сайжруулна гэсэн хуулийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилт хэрэгжиж байна гэж үзэж байна.</p> <p>МБС-ын багшийг тасралтгүй сургаж чадваржуулах, мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалтыг холбогдох байгууллагаас түншлэгч байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг хэдий ч сургалтын үр дүн бодит байдалд хэрхэн гарсныг үнэлэх тогтолцоо сул байна.</p>
9	<p><b>20 дугаар зүйл.</b> <b>Нийгмийн түншлэл</b></p> <p>20.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд дараахь түвшинд ажиллана:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн түншлэлийн хүрээнд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгож чадаж байна уу?</li> <li>- Нийгмийн түншлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн хувьд дэмжлэг, зохицуулалт шаардлагатай байна уу?</li> <li>- Нийгмийн түншлэл хамгийн сайн хэрэгжиж байгаа үйл ажиллагааны ямар чиглэл /сургалт, дадлага, ажлын байр гэх мэт/ байна вэ?</li> <li>- Төрийн болон төрийн бус байгууллагын оролцооны түвшин хэр байна вэ?</li> </ul>	<p>МБСҮЗ, түүний салбар зөвлөлүүд нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа нь дараах асуудалтай холбоотой байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- МБС-ын Үндэсний зөвлөл, салбар зөвлөлүүдийг байгуулсан ч тэдний үйл ажиллагаа байнгын тогтмол бус, хэвийн үйл ажиллагааг хангах санхүүгийн хөшүүрэг байхгүй.</li> <li>- Салбар зөвлөлүүд нь тодорхой санхүүжилт байхгүй тул үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх ажлын алба болон мэргэшсэн ажилтан байхгүй.</li> <li>- Хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдтэй төрийн болон МБС-ын байгууллагуудын түвшинд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг ч мэдээлэл солилцох механизм сул, үр дүнг баталгаажуулах, түгээн дэлгэрүүлэх ажил хийгддэггүй.</li> <li>- Салбарын онцлог, нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг, нэр хүнд, ач холбогдлыг сурталчлан таниулах замаар хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх талаар дорвитой үйл ажиллагаа хийгддэггүй зэрэг байна.</li> </ul>
10	<p><b>26 дугаар зүйл.</b> <b>Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</b></p> <p>26.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн хэрэгжилт хяналт тавих механизм бүрдсэн эсэх?</li> </ul>	<p>МБСҮМАЗТөвөөс хийсэн МБСБ-дын 719 гаруй багш, арга зүйч, нийгмийн түншлэлийн ажилчдаас авсан хуулийн зүйл, заалтын хэрэгждэг эсэхийг тодорхойлсон судалгааны үр дүнгээс харахад “Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага зохион байгуулалт”</p>

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн хяналтын байгууллага хангалттай хэмжээнд хяналт тавьж чадаж байна уу?</li> <li>- Хууль тогтоомжоор тус байгууллагад олгосон эрх хангалттай эсэх?</li> <li>- Тулгарч байгаа асуудал, хүндрэл бэрхшээл?</li> </ul>	буюу хуулийн 2 дугаар бүлгийн хэрэгжилт хамгийн хангалтгүй гэж хариулсан байна.
--	--	---

**3.2.Санал, зөвлөмж**

МБСТ хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлээд үнэлгээ хийсэн зохицуулалт бүрийн хүрээнд дараах санал зөвлөмжийг өгч байна. Үүнд:

д/д	Үнэлгээний хүрээ	Санал, зөвлөмж
1	<p><b>6 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл</b>                      6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ.                      6.3.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх журам, хяналт, хариуцлагын зохицуулалтыг боловсронгуй болгох.</li> </ul>
2	<p><b>8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх</b>                      8.4.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;                      8.4.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээллийн бүрэн агуулгыг тодорхойлох, түүнийг зөв бодитой гаргах, мэдээлэхэд холбогдох байгууллагууд ямар үүрэг, хариуцлага хүлээхийг хуулиар тогтоогоогүй байгааг анхаарч шинээр томъёолон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж засаж сайжруулах;</li> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх, эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>- суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийг үнэн зөв тодорхойлох судалгааны аргаа өөрчлөх, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа ашиглах.</li> </ul>
3	<p><b>12 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага</b>                      12.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн эрэлтэд нийцүүлэн зах зээлийн судалгаа хийж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалт зохион байгуулах чиг үүргийг хуулинд оновчтой, үр дүнтэй байдлаар тусган хэрэгжүүлэх;</li> <li>- Нийгмийн түншлэлийн асуудлыг зохицуулсан хуулийн бусад заалтын хэрэгжилтийг сайжруулахад анхаарах.</li> <li>- Төгсөгчдийн ажлын байрны асуудал, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой тогтоох чиг үүргийг мэргэжлийн сургалтын байгууллагад хуулиар олгох.</li> </ul>
4	<p><b>14 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх</b></p>	Хууль хэрэгжсэнээс хойш МБСБ-ыг байгуулах тусгай зөвшөөрлийг төрийн өмчийн 7 сургууль авсан байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарсан зардлын хувьд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй боловч нийгэмд эерэг нөлөө үзүүлээгүй. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын 60 орчим хувь нь 10-40

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	<p>14.1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна</p> <p>14.2.Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлж болно</p>	<p>хүртэлх ижил мэргэжлээр давхардуулан сургаж илүүдэлтэй ажилтныг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байна.<sup>33</sup> гэсэн судалгааг салбарын яамнаас хийсэн байна. Мөн 2017 оны байдлаар ажилгүйчүүдийн 66% нь техник мэргэжлийн, тусгай дунд болон дээд боловсролтой иргэд байгаа бол үлдсэн 34% нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой иргэд байна. Иймд цаашид хуулийн энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ МБСБ-ыг хүн амын нутагшил суурьшил, бүсчиллийн бодлоготой уялдуулах, орон нутгийн болон тодорхой салбарын хэрэгцээг харгалзан үзэж бодитой тооцоо судалгаанд үндэслэдэг байх зарчмыг баримтлах</p>
5	<p><b>15 дугаар зүйл.Суралцагч элсүүлэх</b></p> <p>15.4.Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Суралцагчид олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тоог нэмэгдүүлэх гол хөшүүрэг мөн хэдий ч зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх чиглэлд түлхүү анхаарч мэдээллийн сан бүрдүүлж, ороцогчдыг байнга мэдээллээр хангах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг энэ чиглэлээр нарийвчлан боловсруулах;</li> <li>- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээллийн бүрэн агуулгыг тодорхойлох, түүнийг зөв бодитой гаргах, мэдээлэхэд холбогдох байгууллагууд ямар үүрэг, хариуцлага хүлээхийг хуулиар тогтоогоогүй байгааг анхаарч шинээр томьёолон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.</li> </ul>
6	<p>16.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.</p> <p>16.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, үнэлгээг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын магадлан итгэмжлэлийн асуудлыг хуульчлах.</li> <li>- Ажил олгогчийн үнэлгээ буюу хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог сайжруулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох,</li> <li>- Хуулийн хэрэгжилтийн түвшинд сургалтын үнэлгээ илүү бодитой, үр дүнтэй, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж улмаар төгсөгчийн ур чадвар сайжрах нөхцөлийг бүрдүүлэх.</li> </ul>
7	<p>17.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах эрхтэй.</p> <p>17.1.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;</p>	<p>2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхлэх Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д дадлагажигч ажилтны хөдөлмөрийн хөлсний талаар зохицуулалтыг шинээр тусгасан тул хуулийн энэ зохицуулалттай уялдуулан Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах.</p>
8	<p>18.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- МБС-ын багшийг тасралтгүй сургаж чадваржуулах, мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалтыг холбогдох байгууллагаас түншлэгч байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг хэдий ч сургалтын үр дүн бодит байдалд хэрхэн гарсныг үнэлэх тогтолцоо сул байгаа тул холбогдох эрх зүйн орчныг бий болгох, хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.</li> </ul>

<sup>33</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан*

	18.2. Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.	- Багшийг урамшуулах талаар хуульд тусган хэрэгжүүлж байгаа хэдий ч багшийн ур чавдарыг үнэлэх урамшууллыг үр дүнтэй нь уялдуулах талаар хуулийн зохицуулалт хангалтгүй байгааг анхаарч шинээр бий болгох.
9	<b>20 дугаар зүйл. Нийгмийн түншлэл</b> 20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд дараахь түвшинд ажиллана:	- Нийгмийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх хуулийн заалтуудын хэрэгжилт төдийлөн хангалттай бус байгаа тул төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд салбар зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах, тэдгээрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, сурталчлах тал дээр анхаарах; - Мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэлийн үр дүнг тооцсон, нөхцөл байдлыг шинжилсэн судалгааг хийх, улсын хэмжээнд нэгтгэн гаргасан тоон мэдээллийг үүсгэх.
10	<b>26 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</b> 26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина. Мөн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хэрэгцээтэй ажилтны захиалгыг бүрэн зөв гаргаж өгөөгүй, дадлагыг удирдамжийн дагуу зохион байгуулаагүй сургалтын байгууллага, ажил олгогчид, холбогдох ажилтнуудад хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгах хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг сайжруулахтай холбогдуулан мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, харилцаанд оролцогчдын эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээлгэх хариуцлагыг тусгаснаар хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.	- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хэрэгцээтэй ажилтны захиалгыг бүрэн зөв гаргаж өгөөгүй, дадлагыг удирдамжийн дагуу зохион байгуулаагүй сургалтын байгууллага, ажил олгогчид, холбогдох ажилтнуудад хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгах; - Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг сайжруулахтай холбогдуулан мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, харилцаанд оролцогчдын эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тусгах
11	12.8.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь <b>тусгай зөвшөөрөл авсан байх</b> бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна.	Хуулийн энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ МБСБ-ыг хүн амын нутагшил, суурьшил, бүсчлэлийн бодлоготой уялдуулах, орон нутгийн болон тодорхой салбарын хэрэгцээг харгалзан үзэж бодитой тооцоо, судалгаанд үндэслэдэг байх зарчмыг баримтлах нь зүйтэй.
12	19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.	Мэргэжилтэй, ур чадвартай чанартай ажилтан, хүний нөөцийг бий болгоход МБСБ-д ажиллаж байгаа багшийг дэмжих санхүүгийн хөшүүрэг үр дүнтэй байж болох ч багшийн ур чавдарын үнэлэмж, төгсөгчдийн ажлын байраар хангагдаж байгаа байдал, олон улсын тэмцээн уралдаанд амжилт үзүүлж байгаа зэрэг бодит үр дүнг харгалзан мөнгөн урамшуулал олгох, хангамж баталгааны асуудлыг Боловсролын тухай хуульд зааснаар зохицуулах хувилбар байж болохыг анхаарах нь зүйтэй.



## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Хууль тогтоомжийн тухай хууль - Аргачлал, гарын авлага, Улаанбаатар, 2016 он;
- “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан” ХНХЯ, 2020 он;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-аас, УИХТГ-ын архив
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2017 он;
- Политехник коллежийн зорилтот мэргэжлийн төгсөгчдийн мөшгих судалгаа ба ур чадварын зөрүүг тодорхойлох нь” Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв. 2020 он;
- Монгол Улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын дүн шинжилгээ. 2019 он;
- Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн тайлан. БСШУЯ, 2019 он;
- Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ. ЮНЕСКО, 2019 он;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018 он;
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2016 оны тайлан [www.assmon.mn](http://www.assmon.mn);
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэг дахин хуваарилах шинжилгээний тайлан, ХНХЯ-2019
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”;
- Фокус бүлгийн ярилцлага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв

## ТОВЧИЛСОН ҮГ

МБСтХ	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБ	Мэргэжлийн бодлого, сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөл
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан

Хавсралт-1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлага /2016-2020 оны төсөв, гүйцэтгэл/

Үзүү лэлт	Задаргаа	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		
		Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	
Орлогын төрөл	Улсын төсвөөс	5,461,719.7	5,444,936.0	8,954,521.6	8,125,283.3	6,821,862.2	5,853,453.3	8,020,334.2	5,725,495.5	10,900,974.3	6,592,220.9	
	Орон нутгийн төсвөөс хуваарилсан											
	Гадаад улс, ОУ-ын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж											
	Хандив, тусламж	Гадаад улс, ОУБ, бусад байгууллага ас										
		Иргэдээс										
	ААНБ-ын цалингийн сангаас төвлөрүүлсэн хөрөнгө	Салбараар										
		Мөнгөн дүнгээр										
Үндсэн үйл ажиллагааны орлогоос /ХЭДС- аас/	10,149,307. 0	10,141,560.8	8,954,521.6	8,125,283.3	-	-	41,004,000.0	18,588,300.0	51,212,030.0	45,700,900.0		
Зарлагын төрөл	Нэг сурагчид ногдох хувьсах зардал	5,377,436.0	5,377,436.0	8,954,521.6	8,125,283.3	6,821,862.2	5,853,453.3	8,020,334.2	5,725,495.5	7,261,820.3	6,592,220.9	
	Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал											
	Ур чадвар эзэмшүүлэх сургалтын зардал											
	Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах зардал											
	Сар бүр олгох тэтгэлэг	10,149,307. 0	10,149,307.0	-	-	-	-	41,004,000.0	18,588,300.0	54,851,184.0	45,700,900.0	
	Бусад зардал /цалин, бичиг хэрэг гэх мэт//	84,283.7	67,500.0									

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*

**Хавсралт-2.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн  
орлого, зарлага /2021 он/**

<b>Үзүүлэлт</b>	<b>Задаргаа</b>	<b>Төсөв /мян.төг/</b>	<b>Гүйцэтгэл /мян.төг/</b>	
<b>Орлогын төрөл</b>	Улсын төсвөөс	8,541,918.0		
	Орон нутгийн төсвөөс хуваарилсан			
	Гадаад улс, ОУ-ын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж			
	Хандив, тусламж	Гадаад улс, ОУБ, бусад байгууллагаас		
		Иргэдээс		
	ААНБ-ын цалингийн сангаас төвлөрүүлсэн хөрөнгө	Салбараар Мөнгөн дүнгээр		
	Туслах үйл ажиллагааны орлогоос /ХЭДС-аас/		61,047,552.0	
<b>Зарлагын төрөл</b>	Нэг сурагчид ногдох хувьсах зардал	8,541,918.0		
	Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал			
	Ур чадвар эзэмшүүлэх сургалтын зардал			
	Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах зардал			
	Сар бүр олгох тэтгэлэг		61,047,552.0	

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн  
үр дагаврын үнэлгээний тайлан*